


# Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

## Төрийн банк ХК

2022 оны 12 дугаар сарын 31



# Агуулга

Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан	1
Товчилсон үгсийн жагсаалт	4
Банкны талаарх мэдээлэл	5
Удирдлагын мэдэгдэл	7
Хараат бус аудиторын дүгнэлт	8
Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	13
Санхүүгийн байдлын тайлан	15
Өмчийн өөрчлөлтийн тайлан	17
Мөнгөн гүйлгээний тайлан	18
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	20
1    Үндсэн үйл ажиллагаа	20
2    Монголын бизнесийн орчин	20
3    Тайлан бэлтгэсэн суурь	20
4    Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	22
5    Голлох нягтлан бодох бүртгэлийн тооцоопол ба үнэлэмж	37
6    Хүү болон түүнтэй адилтгах орлого, зардал	38
7    Телбер хураамжийн срлого, зардал	39
8    Арилжааны цэвэр орлого	39
9    Үйл ажиллагааны бусад (зардал) орлого	39
10   Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын ашиг, алдагдал	40
11   Үйл ажиллагааны зардал	40
12   Орлогын татварын зардал	41
13   Бэлэн мөнгө ба Монголбанкин дахь харилцах	42
14   Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	44
15   Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	44
16   Харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа	45
17   Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө	54
18   Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгө	55
19   Бусад хөрөнгө	57
20   Борлуулах зориулалттай хөрөнгө	58
21   Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хедлэх хөрөнгө	59
22   Үндсэн хөрөнгө	60
23   Биет бус хөрөнгө	61

24	Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өглөг	61
25	Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	62
26	Репо хэлцэл	63
27	Харилцагчдын харилцах, хадгаламж	63
28	Зээлээр авсан эх үүсвэр	64
29	Бусад өр төлбөр	64
30	Энгийн хувьцаа, бусад нөөц ба ногдол ашиг	65
31	Мөнгөн гүйлгээний нэмэлт тодруулга	67
32	Болзошгүй өр төлбөр ба үүрэг	68
33	Урьдчилан тооцолоогүй нөхцөл байдал	68
34	Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ	69
35	Бодит үнэ цэнийн хэмжилт	71
36	Хөрөнгө, өр төлбөрийн төлөх хугацааны дүн шинжилгээ	78
37	Эрсдэлийн удирдлага	80
38	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	95
39	Сегмент тайлганал	97
40	Тайлганалын үеийн дараах үйл явдал	98
41	Орчуулга	98
42	Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт	99

# Товчилсон үгсийн жагсаалт

АОУС	Аудитын олон улсын стандарт
БҮЦБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого
БҮЦАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдал
ДМ	Дефолтын магадлал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗҮЦХА	Зээлийн үнэ цэнийн хулээгдэж буй алдагдал
ЖДУ	Жижиг дунд үйлдвэрлэл
МБ	Монголбанк
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ЧМ	Чанаргүйдлийн магадлал
ЭУХ	Эрсдэлийн удирдлагын хороо

# БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр:	Банк нь 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба лиценз:	Банк нь 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинээр олгосон 5341469 регистрийн дугаар бүхий 900700101 тоот Улсын Бүртгэлийн гарчилгээг зэмшидэг. Банк нь 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр банкны үйл ажиллагааг эрхлэх 26 тоот Тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан.	
Төлөөлөн удирдах зөвлөлийн:	Б.Төлмүн Б.Ганбат Д.Цолモン Б.Сүх-Очир Г.Золбоо Л.Сонор	ТУЗ-ийн дарга (Сангийн яам, Татварын бодловын газрын дарга) ТУЗ-ийн гишүүн (Засагийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэрэүүн дэд дарга) ТУЗ-ийн гишүүн (Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн бодлогын газрын дарга) ТУЗ-ийн гишүүн (Сангийн яам, Санхүүгийн бодловын газрын дарга) ТУЗ-ийн гишүүн (Сангийн яам, Санхүү, төсвийн судвалгааны газрын дарга) ТУЗ-ийн гишүүн (Сангийн яам, Санхүүгийн бодловын газрын, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дараа)
	М.Батжаргал Д.Энхжаргал С.Цэнд-Аюуш	Хараат бус гишүүн Хараат бус гишүүн Хараат бус гишүүн
Гүйцэтгэх удирдлага:	Ө.Гантер Х.Лхагвасүрэн Б.Содонбаатар Э.Батбаяр Б.Амарсанаа А.Батменх М.Гантуяа Г.Энхтамир Л.Болормаа Д.Жадамбаа З.Туяацэцэг Б.Агаанцэрэн Ш.Алтанчимэг Н.Ганзориг	Гүйцэтгэх захирал Бизнесийн бодлого төлөвлөлтийн газрын захирал Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал Зээлийн газрын захирал Хуулийн газрын захирал Дотоод хяналт шалгалтын газрын захирал Санхүүгийн газрын захирал Мэдээллийн технологийн газрын захирал Хүний наавцийн газрын захирал Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Салбарын удирдлагын газрын захирал Даатгалын газрын захирал Комплексийн газрын захирал Үйл ажиллагааны газрын захирал

	Б.Сүгэр Ц.Дамдинсүрэн	Харилцагчийн үйлчилгээний газрын захирал Эрдэлийн удирдлагын газрын захирал
<b>Үйл ажиллагаа:</b>		Мөнгөн хадгаламж зээл, төлбөр тооцоо, гадаад валют, үнэт метагл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо хийх, үнэт цаас гарлах, худалдах, худалдан авах
<b>Ажиллагсадын тоо:</b>		3856
<b>Хаяг:</b>		Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1 "Терийн банк" ХК-ийн байр
<b>Аудитор:</b>		"Грант Торнтон Аудит" ХХК Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүтийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

# Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг билэлүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүйл бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

"Төрийн банк" ХК-ийн ТҮЗ-ийн дарга Б.Тэлмүүн, Гүйцэтгэх захирал Ө.Гантер болон Санхүүгийн газрын захирал М.Гантуяа бид энэхүү тайлангийн 13-19 дүгээр хуудсанд үзүүлсэн банкны санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх банкны санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



Гүйцэтгэх захирал  
Ө.Гантер  
Огноо: 2023.03.10

*М. Гантуяа*

Санхүүгийн газрын захирал  
М.Гантуяа  
Огноо: 2023.03.10



Grant Thornton

## "ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

# Хараат бус аудиторын дүгнэлт

"Төрийн банк" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Зөрчилгүй дүгнэлт

Бид "Төрийн банк" ХК (цаашид "Банк")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй тайлан,
- Санхүүгийн байдлын тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд.

Бидний дүгнэлтээр, "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бух матероиллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлагаа гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттai холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Банкнаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангальтай, зохистой гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

**Аудитын гол асуудал**
**Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулга**

Үйлчлүүлэгчдэд олгосон зээлийн ач холбогдол болон үнэ цэнийн бууралтын үнэлгээнд үндэслэсэн таамаглалуудын субъектив байдлаас шалтгаалан хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуултыг аудитын гол асуудал гэж үзсэн. Олон янзын шийдэл, таамаглалыг ашиглах нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын хорогдуултыг ихээхэн ялгаатай үр дүнд хүргэж болох ба энэ нь Банкны санхүүгийн үр дүнд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Үнэлэмжийн голлох хамрах хүрээ нь Банкны хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт тусгагдсан СТОУС 9-ийн хэрэглээний дагуу үнэ цэнийн бууралтыг тодорхойлох шаардлагуудын тайлбар, зээлийн чанар буурах эрсдэлийн тодорхойлолт болон бизнесийн түншийн санхүүгийн байдал, хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ, макро эдийн засгийн хүчин зүйлсийн хэтийн төлөв, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт зохих ёсоор тусгагдаагүй одоо болон цаашид тохиолдох гадаад хүчин зүйлсийг тусгах нэмэлт зүйлийг ашиглах хэрэгцээ зэрэг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт ашигласан таамаглалыг багтаасан.

**Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ**

Үнэ цэнийн бууралтын аргачлалын хувьд бидний гүйцэтгэсэн аудитын горим дараах зүйлээс бурдсэн:

- Бид Банкны СТОУС 9-д сууриссан үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн бодлоготой танилцаж, түүнийг СТОУС 9-ийн шаардлагуудтай харьцуулалт хийсэн.
- Бид төлөвлөлтийг үнэлж, үнэ цэнийн бууралтын нөөцийг тодорхойлоход ашигласан өгөгдлөд хамаарах хяналтын үйл ажиллагааны үр нөлөөнд сорил хийсэн бөгөөд үүнд зээл үүсэх үед олж авсан ажил гүйлгээний мэдээлэл, дотоод зээлийн чанарын үнэлгээ, өгөгдөл хадгалалт, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт холбогдох интерфейсүүд багтсан болно.
- Бид төлөвлөлтийг үнэлж, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварт хамаарах хяналтын үйл ажиллагааны үр нөлөөнд сорил гүйцэтгэсэн ба үүнд загвар боловсруулах, түүнийг батлах, түүнд тавих байнгын хяналт/баталгаажуулалт, загварын удирдлага, математикийн нарийвчлал зэрэг болно.
- Бид зээлийн эрсдэлийн өсөлтийг Банкнаас зүй зохистой, оновчтой тодорхойлсон эсэх болон үүнээс үүдэн гарах эрсдэлийг олон янзын үе шатанд ангилсан үндэслэлийг шалгасан.
- Эрсдэлд өртөх жишээний хувьд, бид Банкнаас авах арга хэмжээний үе шатыг зүй зохистой, оновчтой эсэхийг шалгасан.
- Бид Банкнаас мердсөн материаллаг загварчлалын таамаглал болон голлох загварчлалын таамаглалд чиглэсэн нэмэлт зүйлс ба загварчлалын таамаглалд өөрчлөлт оруулах нөхцөл байдалд үнэлгээ хийж, сорил гүйцэтгэсэн.
- Банкны удирдлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоололд ашигласан таамаглалын хувьд, бид удирдлагатай уулзалт хийж, олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглан таамаглалыг баримтаар нотлон баталгаажуулсан.
- Бид эрсдэлд өртөх жишээг шалгаж, зээлийн чанар буурах эрсдэлийг цаг тухайд нь тодорхойлох, эрсдэлийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг үнэлэх горимыг гүйцэтгэсэн.
- Бид онолын үндэслэлийн талаар мэдээлэл авч, мердсөн загварчлалын математикийн иж бүрэн байдалд сорил гүйцэтгэсэн.
- Гадаад нөөцөөс авсан өгөгдлийн хувьд, бид ийм өгөгдлийг сонгосон үйл явц, түүний банканд хамааралтай эсэх, эдгээр өгөгдөл тавих хяналт, удирдлагын талаар мэдээлэл авсан;
- Бид тусгай мэдлэг шаардсан чиглэлд мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээс оролцуулсан (жишээ нь, өгөгдөл мэдээллийн найдвартай байдал, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар гэх мэт).
- Бид санхүүгийн тайлангийн тодруулгын үнэн зөв эсэхэд үнэлгээ хийсэн.

## Онцлох асуудал

2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон ба энэхүү хуулийн хүрээнд банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат Банк, бусад банк нь хувьцаат Банк хэлбэртэй байхаар зохицуулалтуудыг тусгаж өгсөн бөгөөд ингэснээр банкны сайн засаглалыг хөгжүүлж, хувьцаа эзэмшилийн хэт төвлөрлийг бууруулан, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох, жижиг хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах үүднээс банкны хувьцаа эзэмших аливаа этгээд, түүний холбогдох этгээдийн хувьд банкны нийт саналын эрхтэй хувьцааны хувь хэмжээ 20 хувиас хэтрэхгүй байхаас гадна банкны тогтолцоонд шударга өрсөлдөөнийг дэмжиж, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх боломж бүрдэх юм.

Банкны тухай хуульд орсон энэхүү нэмэлт өөрчлөлт болон УИХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоолын дагуу Төрийн банк нь 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаагаа олон нийтэд танилцуулан, нийт 37.5 сая ширхэг, 250 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий энгийн хувьцааг буюу нийт хувьцааны 5 хувийг олон нийтэд нээлттэй худалдаж, ХК-ийн буюу нээлттэй Банкны статустай болсон.

## Бусад асуудал

"Төрийн банк" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд "Эрнст Энд Янг Монголия аудит" XXX аудит хийсэн ба зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл "Төрийн банк" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлант багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

## Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх Үүрэг хариуцлага

Банкны удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайлант аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайлант бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсох юм уу татаан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах банкны чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

## *Санхүүгийн тайланын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь ёндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зэрчлийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залilan эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээс санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хувалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Банкны дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохицтой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Банкны тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлээс үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Банк тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжкүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн өрөнхий толилуулга, бүтэц, агуултгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон Гэрээт ажлын партнер нь Н.Эрдэнэцог болно.



  
Н.ЭРДЭНЭЦОГ  
ТЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: 2023.03.10

# Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Үр ашигт хүүний аргачлалаар бодсон хүүний орлого	6	396,145,491	363,500,188
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6	8,784,428	21,973,641
Хүү болон түүнтэй адилтгах зардал	6	(182,859,623)	(190,640,521)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>		<b>222,070,296</b>	<b>194,833,308</b>
Хураамж ба шимтгэлийн орлого	7	34,132,518	29,053,607
Хураамж ба шимтгэлийн зардал	7	(8,828,413)	(6,718,631)
<b>Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого</b>		<b>25,304,105</b>	<b>22,334,976</b>
Арилжааны цэвэр орлого	8	13,461,603	4,006,641
Үйл ажиллагааны бусад зардал	9	(2,559,308)	(17,541,753)
<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>		<b>258,276,698</b>	<b>203,633,172</b>
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн орлого/(зардал)	10	4,157,793	(32,012,890)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>		<b>262,434,491</b>	<b>171,620,282</b>
Ерөнхий удирдлагын зардал	11	(138,280,871)	(110,606,423)
Татварын өмнөх ашиг		<b>124,153,620</b>	<b>61,014,859</b>
Срлогын элбан татварын зардал	12	(26,858,777)	(15,267,271)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>97,294,843</b>	<b>45,747,588</b>
Нэгж хувьцаанд ноогдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох ашиг	30	0.129	257.0

# Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангулавдаж бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>			
Бодит үнэ цэнийн вөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлолын тайландаа бүртгэдэх эрийн хөргөслийн бодит үнэ цэнийн цэвэр вөрчлөлт	30	(15,035,131)	(4,987,873)
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангулавдахаагүй бусад дэлгэрэнгүй орлого – (татварын дараах):</i>			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	30	11,135	-
Нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт	30	(37,950)	(37,378)
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>(15,061,946)</b>	<b>(5,025,251)</b>
<b>Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого</b>		<b>82,232,897</b>	<b>40,722,337</b>

Энэхүү Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгуудын хамт үншина.

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>			
Бэлэн менге ба Монголбанк дахь харилцах	13	726,396,277	250,920,691
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	231,538,852	28,534,316
Үүсмал санхүүгийн хэрэгсэл	15	15,034,433	759,107
Харилцагчдад олгосон зязл ба урьдчилгаа	16	1,868,626,502	2,237,147,348
Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зориулалттай	17	10,896,733	7,310,813
Бодит үнэ цэнийн вөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэдэх санхүүгийн хөрөнгө	17	128,002,947	80,844,572
Бодит үнэ цэнийн вөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэдэх ерийн хэрэгсэл	18	957,771,729	967,315,767
Бодит үнэ цэнийн вөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэдэх ёмийн хэрэгсэл	18	120,466	118,385
Хорогдуулсан өртөөв бүртгэх ерийн хэрэгсэл	18	68,223,496	67,786,597
Бусад хөрөнгө	19	18,279,807	21,266,799
Борлуулах зориулалттай хөрөнгө	20	12,894,113	6,762,299
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	21	2,848,500	2,364,878
Үндсэн хөрөнгө	22	118,046,524	115,918,630
Биет бус хөрөнгө	23	5,940,582	5,630,775
Ашиглах эрхтэй хөрөнгө	24	20,573	53,279
<b>Нийт хөрөнгө</b>		<b>4,164,641,534</b>	<b>3,792,734,256</b>

# Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>Өр төлбөр</b>			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25	315,533,091	115,952,799
Репо хэлцэл	26	333,230,213	153,809,693
Харилцагчдын харилцах, хадгаламж	27	2,749,360,513	2,856,798,045
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	15	2,286,265	1,549,920
Зээлээр авсан эх үүсвэр	28	234,934,137	252,376,321
Бусад өр төлбөр	29	26,360,480	15,847,976
Түрээсийн өглөг	24	197,130	234,557
Орлогын татварын өр төлбөр	12	1,196,135	4,865,246
Хойшлогдсон татварын өр төлбөр	12	5,334,391	2,815,761
<b>Нийт өр төлбөр</b>		<b>3,668,432,355</b>	<b>3,404,250,318</b>
<b>Банкны хувьцаа эзэмшигчидэд ногдох өөрийн хөрөнгө</b>			
Энгийн хувьцаа	30	188,774,063	178,000,000
Нэмж төлгөсөн капитал	30	14,652,725	-
Бусад нөөц	30	14,215,779	29,368,212
Хуримтлагдсан ашиг		278,566,612	181,115,726
<b>Нийт өөрийн хөрөнгө</b>		<b>496,209,179</b>	<b>388,483,938</b>
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө</b>		<b>4,164,641,534</b>	<b>3,792,734,256</b>

Энэхүү Санхүүгийн байдлын тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгудын хамт уншина.



Уг санхүүгийн байдлын тайланг 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдөр батлав:

Гүйцэтгэх захирал  
Ө.Гантер

Санхүүгийн газрын захирал  
М.Гантуяа

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Неецийн сан	Хуримтлаг дсан ашиг	Хоёрдогч еглэг	Нийт өөрийн хөренгэ
<b>2021 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>133,900,000</b>	-	<b>34,393,463</b>	<b>135,368,138</b>	<b>44,100,000</b>	<b>347,761,601</b>
<b>Тайлант жилийн ашиг</b>	-	-	-	<b>45,747,588</b>	-	<b>45,747,588</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-	<b>(5,025,251)</b>	-	-	<b>(5,025,251)</b>
<b>Энгийн хувьцаанд хөвөсөн хоёрдогч еглэг</b>	<b>44,100,000</b>	-	-	-	<b>(44,100,000)</b>	-
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>178,000,000</b>	-	<b>29,368,212</b>	<b>181,115,726</b>	-	<b>388,483,938</b>
<b>2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>178,000,000</b>	-	<b>29,368,212</b>	<b>181,115,726</b>	-	<b>388,483,938</b>
<b>Тайлант жилийн ашиг</b>	-	-	-	<b>97,294,843</b>	-	<b>97,294,843</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-	<b>(15,061,946)</b>	-	-	<b>(15,061,946)</b>
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	-	-	<b>(15,061,946)</b>	<b>97,294,843</b>	-	<b>82,232,897</b>
<b>Өмчид гарсан өөрчлөлт</b>	<b>10,774,063</b>	<b>14,652,725</b>	-	<b>65,558</b>	-	<b>25,492,344</b>
<b>Дахин үнэлгээний хэрэгжсэн дун</b>	-	-	<b>(90,487)</b>	<b>90,487</b>	-	-
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>188,774,063</b>	<b>14,652,725</b>	<b>14,215,779</b>	<b>278,586,812</b>	-	<b>496,209,179</b>

Энэхүү Өмчийн өөрчлөлтийн тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгуудын хамт уншина.

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

<b>Мянган төгрөгөөр</b>	<b>Тодруулга</b>	<b>2022 он</b>	<b>2021 он</b>
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>124,153,620</b>	<b>61,014,859</b>
<b>Тохишуултууд:</b>			
Санхүүгийн деривативуудын бодит үнэ цэнийн өөрчлөлт		(13,538,982)	369,615
Арилжаалах зориулалттай санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт		(2,565,371)	(733)
Өмчлөх бусад үл хэдлэх хөрөнгийн эрдэлийн сан	<b>9</b>	<b>4,641,891</b>	<b>3,553,750</b>
Зээл ба авлагын үнэ цэнийн бууралтын хулээгдэх буй алдагдал	<b>10</b>	(4,157,793)	32,012,890
Үндсэн хөрөнгийн элзэгдэл	<b>11</b>	<b>13,183,381</b>	<b>13,147,220</b>
Биет бус хөрөнгийн хорогдуулга	<b>11</b>	<b>766,441</b>	<b>924,743</b>
Ашиглах эрхтэй хөрөнгийн элзэгдэл	<b>11</b>	<b>32,708</b>	<b>3,621,726</b>
Үндсэн хөрөнгөе данснаас хассаны гарз	<b>11</b>	<b>223,902</b>	<b>174,792</b>
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		(483,622)	-
Зээлээр авсан эх үүсвэрийн хуулийн зардал	<b>31</b>	<b>6,714,912</b>	<b>7,201,098</b>
Гэрээний нехцэл өөрчлөлтийн цавар алдагдал	<b>9,31</b>	-	<b>13,930,889</b>
Гэрээний нехцэл өөрчлөлтийн алдагдалаас үүссэн цэвэр хуулийн хорогдол	<b>31</b>	-	(10,429,557)
Түрээсийн өвлөгийн хуулийн зардал	<b>6</b>	<b>7,572</b>	<b>344,962</b>
Нийгмийн хөгжлийн сангийн царцуулалт	<b>30</b>	(37,950)	(37,378)
Дахин үнэлгээний нөөцийн царцуулалт	<b>30</b>	<b>11,135</b>	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ		(22,880,162)	32,110
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг</b>		<b>106,071,680</b>	<b>125,850,986</b>
<b>Үйл ажиллагааны хөрөнгөөр төлбөрийн өөрчлөлтүүд:</b>			
Монголбанк дахь заавал байлагх нөөц		(33,805,186)	(22,735,604)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		(201,939)	(142,535)
Харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа		371,134,331	(516,812,315)
Бусад хөрөнгө		(788,076)	1,638,393
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		(6,131,814)	(2,168,688)
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		199,580,292	(18,212,994)
Рено хэлцэл		179,420,520	82,567,237
Харилцагчдын харилцах, хадгаламж		(107,437,532)	178,355,689
Бусад өр төлбөр		10,512,504	2,858,698
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>718,354,780</b>	<b>(168,801,133)</b>
Орлогын албан татварын төлөлт	<b>12</b>	(28,782,984)	(11,961,341)
Түрээсийн өвлөгийн хуулийн хэсэгт хамаарах төлөлт	<b>31</b>	(7,572)	(344,962)
Зээлээр авсан эх үүсвэрт төлсөн хүү	<b>31</b>	(6,456,396)	(6,383,780)
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>685,127,828</b>	<b>(187,491,216)</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>			
Санхүүгийн хөрөнгө оруулалт худалдан авалт		(23,970,892,184)	(18,334,174,054)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого		23,659,267,079	18,359,834,907
Үндсэн хөрөнгө худалдан авалт	<b>22</b>	(15,535,177)	(11,960,305)
Биет бус хөрөнгө худалдан авалт	<b>23</b>	(1,076,248)	(1,109,742)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(328,236,530)</b>	<b>12,690,806</b>

# Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Зээлээр татсан эх үүсвэр	31	611,597,875	274,843,524
Зээлээр татсан эх үүсварийн зргэн төлөлт	31	(638,050,526)	(250,173,749)
Түрээсийн өглөгийн үндсэн хэсэгт хамаарах төлөлт	31	(37,427)	(4,256,897)
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хулаан авсан		25,426,788	-
<b>Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>936,610</b>	<b>20,412,878</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсслт (бууралт)</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		797,998,193	952,485,725
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>31</b>	<b>1,165,826,101</b>	<b>797,998,193</b>
<b>Мөнгөн бус үйл ажиллагаанууд:</b>			
Ашиглах эрхтэй хөрөнгө	24	-	479,609
Түрээсийн өглөг	24	-	(479,609)

Энэхүү Мөнгөн гүйлгээний тайланг 20-с 99 дүгээр хуудсан дах уг санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болох тодруулгуудын хамт үншина.

# Санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1. Үндсэн үйл ажиллагаа

"Төрийн банк" (цаашид "Банк" гэх) нь Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хаалттай хувьцаат Банк юм. Банк нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Монгол Улсын Төв банкнаас (цаашид "МБ" гэх) 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр олгосон 26 тоот тусгай зөвшөөрөлтэй.

Банк нь олон нийтээс хадгаламж хүлээн авч, зээл олгох, Монгол болон гадаадад төлбөр тооцоо хийх, валют солих, банкны бусад үйлчилгээг арилжааны болон жижиглэнгийн харилцагчдад үзүүлдэг. Банкны төв байр нь Улаанбаатар хотод байрладаг ба Улаанбаатар хот болон бусад бүс нутаг, аймаг, сум орон нутагт 496 салбартай.

Банкны хувьцааны 49.26%-ийг Монгол улсын Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци 45.03%, олон нийт 5.71% эзэмшиж байна.

Банкны албан ёсны бүртгэлтэй хаяг нь: "Төрийн банк" ХК-ийн байр, Бага тойруу, 7/1, 1-р хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот-210644, Монгол улс

Олон улсын үнэлгээний Bank Moody's Investors Service/Standard & Poor's-ийн үнэлгээгээр тус Банканд В3 үнэлгээ өгсөн.

## 2. Монголын бизнесийн орчин

Монгол Улсын улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, хууль эрх зүй, татвар, хууль тогтоох тогтолцооны хөгжил тасралттүй үргэлжлэх шинж чанартай байгаа ба Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил нь эдгээр өөрчлөлтөөс ихзэхэн хамаардаг.

Коронавируст халдварт (COVID-19)-ын цар тахалтай холбоотой хямралын дараа Монголын эдийн засаг тогтвортой саргэх үе шатанд орсон. "COVID-19"-ын халдварын нөхцөл байдлыг аажмаар сайжруулах, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зараг Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь 2022 оны эдийн засгийн есэлтэд тулхэц болно гэж үзэж байна. Бизнесийн орчныг сайжруулах, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг нэн тэргүүнд сэргээн босгож хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын хүчин чармайлт, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны өргөтгөсөн төлөвлөгөө нь Монголын эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилд зохих хувь нэмэр оруулах төлөвлөгөө байна.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь тус Банкны үйл ажиллагаанд Монголын бизнесийн орчны үзүүлэх нөлөөллийн талаарх удирдлагын үнэлгээг тусгасан. Гэсэн хэдий ч банкны үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх ирээдүйн эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал нь удирдлагын одоогийн хүлээлтээс өөр байж болно.

## 3. Тайлан бэлтгэсэн суурь

### 3.1 Нийцлийн стандарт

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС") болон Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо (СТОУТХ)-ноос гаргасан тайлбаруудын дагуу бэлтгэсэн.

Банк нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулах байгууллагуудад тайлан гаргадаг. Эдгээр санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэх зорилгоор тохируулж, дахин ангилсан Банкны данс, бүртгэлд үндаслэсэн болно.

### 3.2 Бүртгэлийн суурь

Санхүүгийн тайланг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх болон бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн үндсэн

дээр бэлтгэсэн. Бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр, санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр (дахин үнэлсэн хөрөнгүүдээс бусад) тус тус бүртгэнэ.

### 3.3 Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь банкны үйл ажиллагаа явуулж буй тухайн эдийн засгийн орчны мөнгөн тэмдэгт болно. Банкны үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиromжтой илэрхийлж байгаа учраас Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болон Банкны толилуулж буй мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт "Төгрөг" байна. Эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

### 3.4 Харьцуулагдсан мэдээлэл

Харьцуулагдсан мэдээллийг тайлант үеийн толилуулгад оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн дахин ангилна. Санхүүгийн байдлын тайлангийн толилуулгад гарсан гол өөрчлөлтүүдийн нелөө дараах байдалтай байна: "Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө" дээрх Монголбанкинд гэдаад валютыар байршиулсан заавал байлагах неөцийн дүнг "Санхүүгийн байгууллагуудад байршиулсан хөрөнгө" мөрөнд толилуулсан.

### 3.5 Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын өөрчлөлтүүд

Банк нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр болсон зарим стандарт, нэмэлт өөрчлөлтийг анх удаа хэрэгжүүлсэн. Хүчин төгөлдөр мөрдех хугацаа болоогүй өөрчлөлт оруулсан стандарт ба түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд байгаа ба Банк нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа болно.

2022 онд анх удаа хэрэгжүүлсэн Банкны санхүүгийн тайланд материалыг нелөө үзүүлэхүйц шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт байхгүй.

2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь Банкны санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нелөө үзүүлэхээргүй байна.

Банканд хамааралтай дараах стандарт болон нэмэлт өөрчлөлт нь 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдэгдэж эхэлсэн. Үүнд:

- СТОУС 3 "Бизнесийн нээдэл"-д орсон нэмэлт өөрчлөлт - Суурь үзэл баримтлалын хүрээний зөвлөмж
- СТОУС 16 "Түрээс"-д орсон нэмэлт өөрчлөлт - Ковид 19-тэй холбоотой 2021 оны 6 дугаар сарын 30-ныас хойш үйлчлэх Түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлт
- НББОУС 16 "Үндсэн хөрөнгө"-д орсон нэмэлт өөрчлөлт-Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглаж эхлэхээс эмнэх хөрөнгийн орлого
- НББОУС 37 "Ноёц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө"-д орсон нэмэлт өөрчлөлт - Алдагдалтай гэрээ: Гэрээг биелүүлэх өртөг
- Жил бурийн сайжруулалтууд (2018-2020 оны мечлэг):
  - СТОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт-анх удаа хэрэгжүүлсэн охин компани
  - СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл – Санхүүгийн өр төлбөрийг хэрэгсэхгүй болгох '10%' -тай тэнцэх төлбөрийн хураамжийн тест
  - СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт - Түрээсийн урамшуулал
  - НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар

### 3.6 Банкны мөрдөж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдех хугацаа болоогүй НББОУСЗ-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Банк нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Удирдлага нь тухайн бүх өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар Банкны нягтлан бodoх бүртгэлийн бодлогод тусган мөрдөж эхлэхээр төлөвлөж байна.

Үдирдлага нь эдгэр стандарт, нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалан банкны санхүүгийн тайланд томоохон нелөө үзүүлэхийг урьдчилан тооцолоогүй бөгөөд тэдгээрийг доор үзүүлэв. Үүнд:

- СТОУС 17 "Даатгалын гэрээ"
- СТОУС 17 "Даатгалын гэрээ"-нд оруулсан нэмэлт өөрчлөлт (СТОУС 17 ба СТОУС 4-д оруулсан нэмэлт өөрчлөлт)
- НББОУС 1 "Санхүүгийн тайланайн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт - Өр төлберийн богино болон урт хугацааны ангилал
- НББОУС 1 "Санхүүгийн тайланайн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт – НББОУСЗ-өөс 2021 оны 2-р сард НББОУС 1 болон СТОУСын практик мэдэгдэл 2 "Материал байдлын талаар үнэлээмж гарах"-д, нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг сайжруулах зорилготой юм.
- НББОУС 12 "Орлогын татвар" -т орсон нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар
- НББОУС 8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдгаа"-д орсон нэмэлт өөрчлөлт - 2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 8-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтөөр тайлагнаач байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс хөрхэн ялгах ёстойг илүү тодорхой болгож өгсөн.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримталсан болно. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэн мөрдсөн.

### 4.1 Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Эдийн засгийн үр өгөвэжийг Банк хүртэх болон орлогыг найдвартай хэмжих боломжтой бол тэр хэмжээгээр нь орлогыг хүлээн зөвшөөрнө. Эдийн засгийн үр өгөвэж нь Банкнаас гарах бөгөөд зардлыг найдвартай хэмжих боломжтой бол тэр хэмжээгээр нь зардлыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тодорхой шалгуурыг хангасан байх ёстой:

#### Үр ашигт хүүгийн хэмжээний аргачлал

Хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. "Үр ашигт хүүгийн хувь" гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацаанд ирээдүйд авахаар тооцоолсон мөнгөн төлбөр эсхүл орлогыг доорх дүн хүртэл дискаунтчилах хувь хэмжээ юм:

- санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсхүл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

Худалдан авсан эсхүл үнэ цэнэ буурсан хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүг тооцоолдоо Банк санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нэхцэлийг харгалзан ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолдог, гэхдээ хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдоггүй. Худалдан авсан эсхүл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулсан үр ашигт хүүгийн хувийг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулан тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээг ашиглан тооцоолдог. Үр ашигт хүүгийн тооцоолдолд үр ашигт хүүгийн хувийн салшгүй хэсэг болох ажил гүйлгээний өртөг, шимтэл, төлсөн буюу хүлээн авсан цэг багтана. Ажил гүйлгээний өртөгт санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг олж авах, гаргахтай шууд холбоотой нэмэлт зардал орно.

#### Хорогдуулсан өртөг ба нийт дансны үнэ

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн "хорогдуулсан өртөг" нь анхны хүлээн зөвшөөрөлтөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө зөвэл санхүүгийн өр төлбөрөөс үндсэн зээлийн зргэн төлөлтийг хассан дүн, үүн дээр хуримтлагдсан хорогдлыг нэмж эсхүл хассан дүн байна. Хуримтлагдсан хорогдол нь тухайн анхны хүлээн зөвшөөрөх дүн болон төлбөр төлөх дүн хоорондын зөрүүг үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцсон дүн бөгөөд санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулгыг тохируулсан дүн юм. "Санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ" нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын хасагдуулгыг тохируулахаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг юм.

## **Хүүгийн орлого болон зардлын тооцоолол**

Хүүгийн орлого, зардлыг тооцоолоходоо үр ашигт хүүгийн хувийг тухайн хөрөнгийн нийт дансны үнэ (хөрөнгийн үнэ цэнэ буураагүй үед) эсхүл өр төлбөрийн хорогдуулсан өртөгт тооцно.

Харин анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хувьд санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртөгт үр ашигт хүүгийн хувийг тооцох замаар хүүгийн орлогыг тооцно. Хэрэв хөрөнгө нь үнэ цэнийн бууралттай болсон бол хүүгийн орлогын тооцооллыг нийт суурь руу буцаана.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнэ нь буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд тохирнуулсан үр ашигт хүүг хөрөнгийн хорогдуулсан өртөгт тооцох замаар хүүгийн орлогыг тооцоолно. Хөрөнгийн зээлийн эрсдэл сайжирсан ч гэсэн хүүгийн орлогын тооцоолол нь нийт суурь руу буцахгүй.

## **Бусад хүүгийн орлого**

Бусад хүүгийн орлогыг тооцоолоходоо нэрлэсэн хүүгийн хувийг нийт хөрөнгийн үнэ цэнд шулуун шугамаар хамааруулна.

## **Хураамж, шимтгэлийн орлого**

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувьтай салшгүй холбоотой хураамж, шимтгэлийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувь (хэмжээ)-д багтаасан.

Бусад хураамж, шимтгэлийн орлого - үүнд дансны үйлчилгээний хураамж, хөрөнгө оруулалтын менежментийн хураамж, борлуулалтын шимтгэл, байршуулалтын хураамж, синдикатын хураамж зэргийг холбогдох үйлчилгээг гүйцэтгэсэн гэж хүлээн зөвшөөрне. Зээлийн гэрзэний үүрэг нь зээлийг татан авахад хүргэхгүй гэж үзвэл холбогдох зээлийн гэрзэний үүргийн хураамжийг тухайн гэрзэний үүргийн хугацаанд шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрне.

Банкны санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэглүүрийг бий болгосон харилцагчтай хийсэн гэрзэ нь СТОУС 9-ийн болон СТОУС 15-ын хамрах хүрээний нэг хэсэг байж болно. Хэрэв тийм бол Банк СТОУС 9-ийн хамрах хүрээнд хамаарах гэрзэний хасгийг салгаж, хэмжихийн тулд эхлээд СТОУС 9-ийг хэрэглэж, дараа нь СТОУС 15-ыг үлдэх хэсэгт нь хэрэглэна.

Бусад хураамж, шимтгэлийн зардал нь үндсэндээ ажил гүйлгээний болон үйлчилгээний хураамжид хамаарах бөгөөд энэ нь үйлчилгээг хүлээн авах үед гарах зардал юм.

## **Ногдол ашгийн орлого**

Банкны төлбөр хүлээн авах эрх үүссэн үед орлогыг хүлээн зөвшөөрне.

## **Арилжааны цэвэр орлого**

Арилжааны цэвэр орлого нь арилжааны зориулалттай хөрөнгө, өр төлбөртэй холбоотой алдагдлыг хассан олзноос бүрдэх ба энэ нь арилжааны хөрөнгө, өр төлбөртэй холбоотой бүх хэрэгжсэн болон хэрэгжээгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт, хүү, ногдол ашиг, валютын ханшийн зөрүү багтана. Мөн арилжааны цэвэр орлогод гадаад валютын хийсэн арилжааны алдагдлыг хассан олз багтаж ба холбогдох үйлчилгээ үзүүлэх үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрне.

## **4.2 Гадаад валют**

Гадаад валютын хийсэн ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдрийн үйл ажиллагааны валютын ханшаар бүртгэнэ. Арилжааны хөрөнгийг хөрвүүлснээс үүссэн олз, алдагдлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа арилжааны цэвэр орлогоор, харин арилжааны бус хөрөнгийг хөрвүүлснээс үүссэн алдагдлыг хасаж тооцсон олзыг ашиг алдагдлын тайландаа бусад орлого эсхүл бусад зардлаар хүлээн зөвшөөрне. Гадаад валютын илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг балансын тооцооны өдрийн үйл ажиллагааны валютын ханшаар дахин хөрвүүлнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх үнэт цаасаар хөрөнгө оруулалт гэж аngilсан гадаад валютын илэрхийлэгдсэн мөнгөн хэлбэрээр үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэт цаасны хорогдуулсан өргийн өөрчлөлт болон үнэт цаасны дансны үнийн бусад өөрчлөлтөөс үүссэн хөрвүүлэлтийн зөрүүний хооронд дүн шинжилгээ хийнэ. Хорогдуулсан өргийн

өөрчлөлттэй холбоотой хөрвүүлэлтийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрч, дансны үнийн бусад өөрчлөлтийг өөрийн өмчид хүлээн зөвшөөрнэ.

Гадаад валютаарх түүхэн өртгээр хэмжигддэг мөнгөн бус зүйлийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнийг гадаад валютаар хэмжсэн мөнгөн бус зүйлийг бодит үнэ цэнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх өмч гэх мэт мөнгөн бус зүйлийн хөрвүүлэлтийн зөрүүг бодит үнэ цэнийн олз, алдагдлын хэсэг болгон тайлагнаа. Бусад дэлгэрэнгүй орлогын бодит үнэ цэнийн дараа үеийн өөрчлөлтийг сонгосон өмчийн хөрөнгө оруулалтад ангилагдсан өмч зораг мөнгөн бус зүйлийн хөрвүүлэлтийн зөрүүг өмчийн бодит үнэ цэнийн нөөцэд сруулна.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үндсэн валютаас бусад валютаар илэрхийлэгдсэн бүх хөрөнгө, ер төлбөр болон ажил гүйлгээг тайлагналын өдрөөрх ханшаар хөрвүүлнэ. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт өөрчлөгдөөгүй.

Нэлтгэлд хөрөнгө, ер төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлнэ. Тайлант хугацаанд гарсан орлого болон зардлыг тайлант үеийн дундаж ханш ашиглан хөрвүүлнэ. Хөрвүүлэлтээс үссэн ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогын өмчид гарсан валютын ханшийн тэгшигтиалийн нөөц дансанд хүлээн зөвшөөрнэ. Гадаад аж ахуй нэгжийг борлуулах үед түүнд хамаарах хуримтлагдсан ханшийн зөрүүг ашиг алдагдлаар дахин ангилах ба борлуулалтын олз, гарзын нэг хэсээр хүлээн зөвшөөрнэ. Гадаадын аж ахуй нэгжийг худалдан авсантай холбоотой үссэн гүдвид болон зах зээлийн үнийн тохирууллыг тухайн аж ахуйн нэгжийн хөрөнгө, ер төлбөрөөр бүртгэх ба тайлагналын өдрийн хаалтын ханш ашиглан хөрвүүлнэ.

Тодорхой ажил гүйлгээний гэрээн дээр тусгасан ханш болон гүйлгээ хийгдсэн өдрийн дундаж ханшийн хоорондох зөрүүг гадаад валют арилжааны алдагдлыг хасаж тооцсон олз руу багтааж арилжааны цэвэр орлогод бүртгэнэ.

Банкнаас санхүүгийн тайлан бэлтгэхдээ ашигласан жилийн эцсийн ханшийг дараах байдлаар харуулав. Үүнд:

Валют	2022 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
Ам.доллар	3,444.60	2,848.80
Евро	3,669.02	3,222.99
Рубль	48.85	38.34
Юань	495.40	447.15
Иен	26.07	24.74
Фунт	4,156.60	3,836.19
Вон	2.73	2.40

### 4.3 Орлогын албан татвар

Тайлант жилийн орлогын албан татвар нь тухайн тайлант хугацааны болон хойшлогдоон татвараас бүрдэнэ. Орлогын албан татварыг өмчид шууд хүлээн зөвшөөрсөн зүйлд хамарагхаас бусад тохиолдолд ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнэ.

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өлтөгийн запруулга юм. Санхүүгийн тайлан гаргаж батлуулахаас өмнө татвар ногдох ашиг, алдагдлыг тооцоолсон зохих татварын тайлант гаргана. Татварын алба татварын хууль тогтоомжийг тайлбарлах, татварын тооцоололд хяналт тавихдаа илүү хатуу чанга байр суурьтай байж болох талтай. Энэ үүднээс татварын алба зарим ажил гүйлгээнд нэмэлт татвар төлөхийг шаардаж магадгүй юм. Үүнээс шалтгаалан ихээкэн хэмжээний нэмэлт татвар, торгууль, алданги төлөх шаардлага үүсэх магадлалтай. Татварын хяналт шалгалт нь тухайн тайлант жилээс өмнөх хуванлийн 3 жилийг хамарч болно. Тодорхой нөхцөл байдалд татварын хяналт шалгалт нь бүр ч олон жилийг хамруулах боломжтой байдаг.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг түр зөвүүний хувьд өр төлбөрийн аргыг ашиглан тооцоолно. Бизнесийн нэгдэл биш ажил гүйлгээний гүүдвил, хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлтээс үссэн хойшлогдсон орлогын албан татвараас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварыг хөрөнгө болон өр төлбөрийн татварын сууриудын хооронд үссэн бүх түр зуурын зөрүү болон тэдгээрийн санхүүгийн тайлангийн зорилгоорх дансны үнээр хүлээн зөвшөөрөх ба ажил гүйгэ хийх үед нягтлан бодож бүртгэлийн ашиг ба татвар ногдох орлого, алдагдлын аль алинд нэлээлхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийг зөвхөн түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед хүлээн зөвшөөрнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдэж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээнд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсхүл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ.

Монгол Улс банкны үйл ажиллагаанд олон төрлийн татвар ногдуулдаг. Эдгээр татварыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бусад зардлын бүрэлдэхүүн хэсэгт тусгасан.

## 4.4 Санхүүгийн хэрэглүүр

### 4.4.1 Хүлээн зөвшөөрөлт ба анхдагч хэмжилт

Банк нь зээл, урьдчилгаа, хадгаламж, гаргасан өрийн үнэт цаас, хөёрдогч өр төлбөрийг үссэн өдрөөр нь хүлээн зөвшөөрдэг. Бусад бүх санхүүгийн хэрэглүүрийг (санхүүгийн хөрөнгийн ердийн худалдан авалт, борлуулалтыг оруулаад) Банк нь өрөөний нэг тал болон арилжаа хийсэн өдрөөр хүлээн зөвшөөрнэ.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Түүнчлэн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх эзүйслийн хувьд худалдан авах эсхүл гаргахтай шууд холбоотой ажил гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээр хэмжинэ.

### 4.4.2 Ангилал

#### Санхүүгийн хөрөнгө

Анхдагч хүлээн зөвшөөрөлтэд санхүүгийн хөрөнгийг Хорогдуулсан өртөг, Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого (БҮЦБДО), Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдлаар (БҮЦАА) хэмжин ангилна.

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг өрөөний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшидэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн,
- Санхүүгийн хөрөнгийн өрөөний нөхцөлүүд нь тодорхой нэг өдөр мөнгөн урсгал бий болгодог ба энэ нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр (SPPI) байвал.

Өрийн хэрэглүүрийг зөвхөн дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд болон БҮЦАА-р ангилагдаагүй үед бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжинэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг өрөөний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшидэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн,
- Санхүүгийн хөрөнгийн өрөөний нөхцөлүүд нь тодорхой нэг өдөр мөнгөн урсгал бий болгодог ба энэ нь зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр (SPPI) байвал.

Борлуулах зорилгоор эзэмшигэгүй өмчийн хөрөнгө оруулалтыг анхлан хүлээн зөвшөөрөхдөө Банк нь бусад дэлгэрэнгүй орлогын бодит үнэ цэнийн дараа үеийн өөрчлөлтийг харуулах үүднээс үүнийг сонгож болно. Энэ сонголтыг хөрөнгө оруулалт тус бүрээр хийнэ.

Бусад санхүүгийн хөрөнгийг БҮЦАА-аар хэмжин ангилна.

Түүнчлэн анхдагч хүлээн зөвшөөрөлтэд банк нь санхүүгийн хөрөнгийг БҮЦАА-гийн тохиолдолд хорогдуулсан өртгөөр эсхүл БҮЦБДО-оор хүлээн зөвшөөрч болох ба ингасэн тохиолдолд энэ нь үүсэж болзошгүй нягтлан бодож бүртгэлийн үл нийцлийг арилгах эсхүл бууруулах юм.

## **Бизнес загварын үнэлгээ**

Хөрөнгийг багцын түвшинд эзэмших бизнесийн загварын зорилгод банк үнэлгээг хийдэг, учир нь энэ нь бизнесийг удирдах, удирдлагад мэдээлэл өөхөн арга замыг хамгийн сайн тусгаж өгдөг. Харгалzan үзэх мэдээлэлд дараах эйлс орно. Үүнд:

- Багц болон тэдгээр бодлогын үйл ажиллагаанд тусгасан бодлого, зорилтууд. Ялангуяа, удирдлагын стратеги нь гэрээний хүүгийн орлого олох, тодорхой хүүгийн хувь хэмжээг барих, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг тэдгээр хөрөнгийг санхүүжүүлж буй өр төлбөрийн хугацаатай тааруулах эсхүл хөрөнгийг борлуулах замаар мөнгөн урсгалыг хэрэгжүүлахэд чиглэгдсэн эсэх талаарх мэдээлэл;
- багцын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, банкны удирдлагад тайлапнах талаарх мэдээлэл;
- бизнесийн загварын гүйцэтгэлд нэвтрэх буй эрсдэлүүд (мөн бизнесийн загварын зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө) болон эдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж байгаа талаарх мэдээлэл;
- урамшууллыг бизнесийн менежерүүдэд хэрхэн олгодог вэ - жишээ нь. урамшуулал нь удирдаж буй хөрөнгийн бодит үнэ цэне эсхүл гэрээний дагуу цуглуулсан мөнгөн урсгалд үндасны эсэх; болон
- өмнөх үеийн борлуулалтын давтамж, хэмжээ, хугацаа болон борлуулах шалтгаан, цаашдын борлуулалтын үйл ажиллагааны талаарх мэдээлэл. Гэхдээ борлуулалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тусад нь салгаж авч үзэхгүй, харин үүнийг санхүүгийн хөрөнгийг удирдах талаар Банкны тодорхойлсон зорилт хэрхэн хэрэгжиж, мөнгөн урсгал хэрхэн хэрэгжиж байгаа талаарх өрөнхий үнэлгээний нэг хэсэг болгон авч үнэ.

## **"Зөвхөн үндсэн төлбөр ба хүү төлөлт" ("SPPI") гэрээний мөнгөн урсгалын шинж чанарын сорилт**

Энэхүү үнэлгээний зорилгоор "үндсэн төлөлт" нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ гэж тодорхойлгдана. "Хүү" нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, цаг хугацааны тодорхой үеийн үндсэн төлөлтийн үлдэгдэлтэй холбоотой зээлийн эрсдэл, бусад үндсэн зээлийн эрсдэл, зардал (тухайлбал, хөрөнгө чадварын эрсдэл ба захиргааны зардал) болон ашгийн хэмжээг харгалzan авч үзсэнээр тодорхойлгддог. Гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлөлтөөс бүрдэж буй эсэхийг үнэлэхдээс банк нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэхцэлийг авч үзэдэг. Үүнд санхүүгийн хөрөнгө нь гэрээний мөнгөн урсгалын хугацаа эсхүл хэмжээг өөрчилж болох гэрээний нэхцэлийг агуулсан эсэх болон энэ нэхцэлийг хангахгүй байгаа эсэх зөргийг үнэлэх багтана.

Үнэлгээ хийхдээ Банк дараах эйлийг авч үнэ:

- мөнгөн урсгалын хэмжээ, хугацааг өөрчлөх урьдчилан тооцоогүй үйл явдал;
- санхүүгийн хараат байдлын шинж тэмдэг;
- урьдчилсан төлөлт болон сунгах нэхцел;
- тодорхой хөрөнгөөс мөнгөн урсгал руу банкны нэхэмжлэлийг хязгаарлах нэхцел (жишээ нь: ашиглалтгүй хөрөнгийн зохицуулалт); болон
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалzan үзэхийг өөрчилдэг шинж чанарууд - жишээлбэл. хүүгийн хэмжээг үе үе дахин тохируулах.

Банк нь урт хугацаат тогтмол хүүтэй зээлийн багцыг эзэмшиж байгаа ба хүүгийн түвшинг тогтмол хугацаанд шинэчлэн тогтоох боломжтой. Энэхүү дахин тохируулах эрх нь өөрчлөлт хийх тухайн үеийн зэхээний ханшаар хязгаарлагддаг. Зээлдэгч нар шинэчилсан хүүг хүлээн зөвшөөрөх эсхүл зээлээ торгуульгүйгээр буцаан эргүүлэн төлөх боломжтой. Банк нь тэдгээр зээлийн гэрээний мөнгөн гүйлгээг зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр гэж тодорхойлсон ба энэ сонголт нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, зээлийн эрсдэл, зээлийн бусад үндсэн эрсдэл, үндсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой зардлыг харгалzan үзсэнээр хүүгийн хэмжээг өөрчилдэг.

## **Дахин ангилал**

Банк нь санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараа өөрчилсөнээс хойших хугацааг эс тооцвол санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараах үед дахин ангилдадтүй. Санхүүгийн өр төлбөрийг хэзээ ч дахин ангилдаггүй.

### **Санхүүгийн өр төлбөр**

Банк нь санхүүгийн өр төлбөрөө хорогдуулсан өргөвөр эсхүл БҮЦАА-р хэмжин ангилдаг.

#### **4.4.3 Үл хүлээн зөвшөөрөлт**

##### **Санхүүгийн хөрөнгө**

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний гэрээний эрх дуусгавар болох үед эсхүл санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн үндсэн бүх эрдэл, үр өгөөжийг шилжүүлэх үйл ажиллагаагаар гэрээний мөнгөн гүйлгээг хүлээн авах эрхийг шилжүүлэх үед, эсхүл банк нь өмчлөлийнхөө үндсан бүх эрдэл, үр өгөөжийг шилжүүлсан болон хадгалан авч үлдсэн ч гэсэн санхүүгийн хөрөнгийн хяналтыг тогтоон авч үлдэвгүй бол Банк нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн дансны үнэ (эсхүл үл хүлээн зөвшөөрөгдсэн хөрөнгийн тухайн хэсэгт хуваарилсан дансны үнэ) болон (i) хүлээн авсан дун (шинээр хүлээн авсан өр төлбөрийг хассан шина хөрөнгийг оруулаад) ба (ii) бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзын хоорондох зэрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

БҮЦБДО-оор илэрхийлсэн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хувьд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөн аливаа хуримтлагдсан олз/гарзыг тухайн үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй. Банкны үүсгэсэн эсхүл хадгалсан үл хүлээн зөвшөөрөгдхөө шаардлагыг хангаж шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн аливаа хүүг тусдаа хөрөнгө эсхүл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

Банк нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг шилжүүлэх хэлцлийг хийдэг ба харин шилжүүлсэн хөрөнгийн эрдэл, үр өгөөжийг бухэлд нь эсхүл зарим хэсгийг нь вөртөө хадгалан авч үлдэг. Ийм тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөггүй. Ийм ажил гүйлгээний жишээ нь үнэт цаасаар зээл олгох болон борлуулах, буцаан худалдан авах хэлцэл юм.

Хөрөнгийг нийт үр өгөөжтэй нь хамт гуравдагч этгээдэд худалдахад уг хэлцлийг борлуулах, буцаан худалдан авах хэлцэлтэй адил баталгаатай санхүүжилтийн хэлцэл гэж тооцдог, учир нь банк ийм хөрөнгийн эрдэл, үр өгөөжийг бухэлд нь вөртөө хадгалан авч үлддэг.

Банк санхүүгийн хөрөнгийн бүх эрдэл, үр өгөөжийг вөртөө хадгалан үлдээдэггүй, шилжүүлдэггүй, мөн уг хөрөнгийн хяналтыг хөвөэр хадгалдаг хэлцлийн хувьд, банк нь вөрийн хувь оролцооны хэмжээгээр уг хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө.

Зарим тодорхой хэлцлийн хувьд Банк нь шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үүргээ хадгалан авч үлддэг. Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

##### **Санхүүгийн өр төлбөр**

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл цуцалсан эсхүл хугацаа нь дууссан үед банк нь санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө.

#### **4.4.4 Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт**

##### **Санхүүгийн хөрөнгө**

Санхүүгийн хөрөнгийн нөхцөлийг өөрчилсөн тохиолдолд банк нь өөрчлөлт орсон хөрөнгийн мөнгөн гүйлгээнд зөрүү байгаа засэхийг үнэлнэ. Харэв мөнгөн гүйлгээнд зөрүү байгаа бол анхны санхүүгийн хөрөнгийн гэрээ дуусгавар болсон гэж үзнэ. Энэ тохиолдолд анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч (Тодруулга 4.4.3-г үзнэ үү) шинэ санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч, холбогдох хэлцлийн зардлыг нэмж тооцно.

Хэрэв хорогдуулсан ёртгөөр тооцсон өөрчлөлт орсон хөрөнгийн мөнгөн гүйлгээнд зөрүү байхгүй бол уг өөрчлөлт нь санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй. Энэ тохиолдолд банк нь санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолж, нийт дансны үнийг тохицуулснаар үүсэх дүнг ашиг, алдагдалд өөрчлөлтийн олз, гарз гэж хүлээн зөвшөөрне. Хэрэв зээлдагчийн санхүүгийн хүндэрэлийн улмаас ийм өөрчлөлт орсон бол (Тодруулга 4.4.6-г үзнэ үү) олз, гарзыг үнэ цэнийн бууралтын гарын хамт бүртгэнэ. Бусад тохиолдолд хүүгийн орлогоор бүртгэнэ.

#### **Санхүүгийн өр төлбөр**

Банк нь санхүүгийн өр төлбөрийн нөхцөлд өөрчлөлт орсон, мөн өөрчлөлт оруулсан өр төлбөрийн мөнгөн гүйлгээ нь зөрүүтай бол түүнийг үл хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд өөрчилсөн нөхцөл дээр үндэслэсэн санхүүгийн шинэ өр төлбөрийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Дуусгавар болсон санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ болон өөрчилсөн нөхцөлтэй шинэ санхүүгийн өр төлбөрийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### **4.4.5 Цэвэр дүн гаргах (Хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь хаах)**

Холбогдох хууль шийдвэрийг сахин биелүүлэх хүрээнд хүлээн зөвшөөрсэн дунд цэвэр дүн гаргах шаардлага байгаа бол эсхүл данс тооцоог цэвэр дүнгээр гаргах зорилготой бол эсхүл хөрөнгийг борлуулах ба өр төлбөрийг барагдуулахыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх бол хөрөнгө ба өр төлбөр болон орлого ба зардлыг хооронд нь хааж, цэвэр дүнг санхүүгийн тайланд тайлагнана.

Орлого, зардлыг зөвхөн СТОУС-ын дагуу гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд цэвэр дүнгээр гаргана эсхүл банкны арилжааны үйл ажиллагаа дахь ижил төстэй бүлэг ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг тооцоолож үүднээс цэвэр дүнг гаргана.

#### **4.4.6 Үнэ цэнийн бууралт**

БҮЦАА-р хэмжээгүй дараах санхүүгийн хэрэглүүрүүдийн хүлээгдэж буй эзэлийн алдагдлыг ирээдүйн төлөвийн үндсэн дээр үнэлдэг:

- хорогдуулсан ёртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө
- түрэсийн авлага
- зээл олгох зээлийн үүрэг
- санхүүгийн баталгааны гарээ

Үнэ цэнийн бууралтын гарзыг өмчийн хөрөнгө оруулалт дээр хүлээн зөвшөөрдөггүй.

Банк нь алдагдлын неөцийг ашиглалтын хугацааны хүлээгдэж буй эзэлийн алдагдлын сантай тэнцүү хэмжээгээр тооцдог ба дараахаас бусад тохиолдолд тэдгээрийг 12 сарын хүлээгдэж буй эзэлийн алдагдал гэж тооцдог:

- тайлангийн өдрөөр зээлийн эрсдэл багатай гэж тодорхойлогдсон ерийн үнат цаасаарх хөрөнгө оруулалт; болон
- Зээлийн эрсдэл нь анхдагч хүлээн зөвшөөрөлтөөс хойш бодитойгоор нэмэгдээгүй бусад санхүүгийн хэрэглүүр.

Зээлжих эрсдэлийн үнэлгээ нь "хөрөнгө оруулалтын зэрэглэл" гэсэн дэлхийн хэмжээний тодорхойлжийт тэнцэх үед банк нь ерийн үнат цаасыг эрсдэл багатай гэж үзнэ.

12 сарын хүлээгдэж буй эзэлийн алдагдал гэдэг нь тайлант өдрөөс хойших 12 сарын дотор санхүүгийн хэрэглүүр дээр үүргээ үл биелүүлэх үйл явдлаас үүдэн бий болох хүлээгдэж буй эзэлийн алдагдал юм.

Ашиглалтын хугацааны хүлээгдэж буй эзэлийн алдагдал гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацаанд үүргээ үл биелүүлэх үйл явдлаас үүдэн бий болох хүлээгдэж буй эзэлийн алдагдал юм.

#### **Хүлээгдэж буй эзэлийн алдагдлын хэмжилт**

Ашиглалтын хугацааны хүлээгдэж буй эзэлийн алдагдал болон 12 сарын хүлээгдэж буй эзэлийн алдагдлыг хоёуланд нь санхүүгийн хэрэглүүрийн үндсэн багцын шинж чанараас шалтгаалан сапангид эсхүл хамтад нь тооцоолдог.

Банк нь тайлангийн хугацаа бүрийн эцэст санхүүгийн хэрэглүүрийн үлдэгдэл ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй төлбөрийн үүргээ биелүүлээгүй эрсдлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэл анх хүлээн зөвшөөрснээс хойш нэмэгдсэн эсэхэд үнэлгээ хийх бодлогыг гаргасан. Энэ талаар Тодруулга 38.1.2-д дэлгэрэнгүй тайлбарласан.

Дээрх үйл явц дээр үндэслэн, банк нь санхүүгийн хэрэглүүрээ дор дурдсаны дагуу Шатлал 1, Шатлал 2, Шатлал 3, Худалдан авсан эсхүл зээлийн үнэ цэне буурсан гэж бүлэглэдэг:

- Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед банк нь 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдал дээр үндэслэн нөөцийг хүлээн зөвшөөрдэг. Шатлал 1-ийн зээлд мөн зээлийн эрсдэл сайжирсан болон Шатлал 2-осс зээлийг дахин ангилсан зээлүүд багтана.
- Шатлал 2: Зээл үүссэнээс хойш зээлийн эрсдэл нэмэгдсэн тохиолдолд банк нь ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг бүртгэдэг. Шатлал 2-ын зээлд зээлийн эрсдэл сайжирсан болон Шатлал 3-аас зээлийг дахин ангилсан зээлүүд багтана.
- Шатлал 3: Зээлийн үнэ цэнэ буурсан гэж тооцогдсон зээл. Банк нь ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг бүртгэнэ.
- Худалдан авсан эсхүл зээлийн үнэ цэнэ буурсан: Худалдан авсан эсхүл зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгө нь анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө юм. Худалдан авсан эсхүл зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнээр бүртгэж, хүүгийн орлогыг зээлийн тохируулсан үр ашигт хүүгийн түвшин дээр үндэслэн дараа үед хүлээн зөвшөөрдэг. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг зөвхөн хүлээгдэж буй зээлийн алдагдлын дараа үед өөрчлөлт гарсан тохиолдолд л хүлээн зөвшөөрч, чөлөөлдөг.

Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь дараах байдлаар тодорхойлогддог Дефолтын магадлал (PD), Дефолт болох үеийн үлдэгдэл (EAD) болон Дефолт болох алдагдал (LGD)-ын дискаунтлагдсан бүтээгдэхүүн юм:

Дефолтын магадлал гэдэг нь тухайн цаг хугацаанд үүргээ биелүүлж чадахгүй байх (дефолт) магадлалын тооцоолол юм. Хэрэв уг зээлийг өмнө нь үл хүлээн зөвшөөрөгүй ба багцад байсаар байгаа бол үнэлсэн тодорхой хугацаанд нь дефолт тохиолдно.

Дефолт болох үеийн үлдэгдэл гэдэг нь ирээдүйд дефолт тохиолдоход үүсэх зээлийн үлдэгдлийн тооцоолол юм. Үүнд гэрээнд заасан хуваарийн дагуу үндсан зээл болон хүүгийн төлөлт хийгдэж буй эсэх, зээл төлөлтийн хэмжээ буурах болон төлөгдөөгүй төлбөрөөс үүссэн хуримтлагдсан хүү зэрэг тайлангийн өдрөөс хойших эрсдлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг харгалзан үздэг.

Дефолт болох алдагдал гэдэг нь тухайн цаг хугацаанд дефолт гарсан тохиолдолд үүсэх алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу төлөх ёстой мөнгөн гүйлгээ болон барьцаа хөрөнгийг борлуулсанас ирэх хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү дээр суурилдаг. Энэ нь ихэвчлэн дефолт болох үеийн үлдэгдлийн хувиар илэрхийлгэддэг.

Дефолтын магадлал (PD), Дефолт болох үеийн үлдэгдэл (EAD) болон Дефолт болох алдагдал (LGD)-ын талаар Тодруулга 37.1.1-д дэлгэрэнгүй тусгасан.

#### **Бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгө**

Зээлдэгчийн санхүүгийн хүндэрлийн улмаас санхүүгийн хөрөнгийн нөхцөлийг дахин тохиролцох, өөрчлөх эсхүл одоо байгаа санхүүгийн хөрөнгийг шинээр солих тохиолдолд уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэх талаар үнэлгээ хийх (Тодруулга 4.4.4-г үзнэ үү) ба хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах байдлаар хэмждэг.

- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоо байгаа хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлтэд хүргэхгүй бол өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгөөс бий болох хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь одоо байгаа хөрөнгийн дутагдаж байгаа мөнгөн хөрөнгийг багтаасан эсэхийг тооцоолно.
- Хэрэв хүлээгдэж буй бүтцийн өөрчлөлт нь одоо байгаа хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлтэд хүргэх бол шинэ хөрөнгийн хүлээгдэж буй бодит үнэ цэнийг үл хүлээн зөвшөөрөгдхөг одоо байгаа санхүүгийн хөрөнгийн эцсийн мөнгөн ургсал гэж үзнэ. Энэ дунг үл хүлээн зөвшөөрөхээр хүлээгдэж буй өдрөөс эхлэн тайлангийн өдөр хүртэлх хугацаанд одоо байгаа санхүүгийн хөрөнгийн анхны үр ашиг хүүгийн түвшинг ашиглан дискаунталсан мөнгөн хөрөнгийн дутагдлыг тооцоолоход оруулсан.

## Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө

Тайлангийн өдөр тус бүрээр банк нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө болон БҮЦБДО-д бүртгэсэн өрийн санхүүгийн хөрөнгөд зээлийн үнэ цэнэ буурсан эсэхэд үнэлгээ хийдэг. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоопсон мөнгөн гүйлгээнд сөрөг нөлөө үзүүлэх нег буюу хэд хэдэн үйл явдал тохиосон тохиолдолд санхүүгийн хөрөнгийг "зээлийн үнэ цэнэ буурсан" гэж үзээ. Санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ бууралтын нотолгоо нь дараах ажиллагдах боломжтой өгөгдлийг багтаасан:

- зээлдэгч нь санхүүгийн ноцтой хүндрэлтэй учирсан;
- үүргээ билэлүүлээгүй эсхүл төлөлтийн хугацаа хэтрүүлсэн гэх мэтээр гэрээг зерчсөн;
- зээл болон урьдчилгааг дахин бүтэцлэхийг банк хүлээн авахгүй байх нехцэл;
- зээлдэгч дампуурах болон бусад санхүүгийн өөрчлөн зохион байгуулалтад орох магадлалтай болсон; эсхүл
- санхүүгийн хүндрэлээс болж үнат цаасны идэвхтэй зах зээлээс алга болсон.

Гэрээний мөнгөн гүйлгээ хийгдэхгүй байх эрсдэл буурсан болон үнэ цэнийн бууралтын бусад үзүүлэлт байхгүй болсох гэх нотолгоо үгүй тохиолдолд зээлдэгчийн нехцэл байдал муудсаны улмаас дахин тохиролцсон зээлийг ихэвчлэн зээлийн үнэ цэнэ буурсан гэж үздэг. Өренд оруулсан хөрөнгө оруулалт нь зээлийн үнэ цэнийн бууралттай эсэх талаар үнэлгээ хийхдээ, банк дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг.

- Бондын өгөөжид тусгагдсан зээл төлөх чадварын зах зээлийн үнэлгээ.
- Үнэлгээний агентлагуудын зээл төлөх чадварын талаарх үнэлгээ.
- Тухайн орны шинэ өр гаргах талаар капиталын зах зээлд нэвтрэх чадвар.

## Санхүүгийн байдлын тайланда хүлээгдэж буй зээлийн алдагдлыг толилуулах

Санхүүгийн байдлын тайланда толилуулсан хүлээгдэж буй зээлийн алдагдлыг дараах байдлаар харуулав:

- хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө: хөрөнгийн нийт дансны үнээс хасагдсан;
- БҮЦБДО-р хэмжсэн өрийн хэрэглүүр: эдгээр хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэ учраас санхүүгийн байдлын тайланда алдагдлын хасагдуултыг хүлээн зөвшөөрөхгүй. Гэхдээ алдагдлын хасагдуултыг тусгаж, бодит үнэ цэнийн нөөцед хүлээн зөвшөөрнө.
- зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээ: ерөнхийдөө дараах тохиолдолд нөөц болгон тооцно;
  - Татаж аваагүй зээлийн үүргийн ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоходоо, банк нь хүлээгдэж буй ашиглалтын хугацаанд татаж авах зээлийн үүргийн хүлээгдэж буй хэсгийг тооцоолдог. Хүлээгдэж буй бэлэн мөнгөний хомдолыг зээлийн хүлээгдэж буй үр ашигт хүйтэй ойролцоо хэмжээгээр дискаунтлана.
  - Санхүүгийн хэрэглүүр нь татаж авсан болон татаж аваагүй бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан бол, банк нь зээлийн үүргийн бүрэлдэхүүн хэсэг дэх хүлээгдэж буй зээлийн алдагдлыг татаж авсан бүрэлдэхүүн хэсгээс тусад нь тодорхойлох боломжгүй: Банк хоёр бүрэлдэхүүн хэсэгт хөүүлэнд нь хосолсон алдагдлын хасагдуултыг толилуулдаг. Хосолсон дүнг татан авсан бүрэлдэхүүн хэсгийн нийт дансны үнээс хассан байдлаар толилуулна. Татаж авсан бүрэлдэхүүн хэсгийн нийт дүнгээс хэтэрсэн аливаа алдагдлын хасагдуултыг нөөцеер тусгана;
  - Баталгаа тус бүрээр банкны өр телбэрийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс орлогын тайланда хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцээр хэмжинэ. Энэ зорилгоор Банк нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг эзэмшигчид учирсан зээлийн алдагдлыг нөхөхийн тулд хүлээгдэж буй телбэрийн өнөөгийн үнэ цэнэд үндэслэн тооцоолдог. Хомдолыг эрсдэлтэй холбоотой эрсдэлийн тохиуулсан хүүгийн хэмжээгээр дискаунтлана. Санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотой хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Нөөцийн хүрээнд хүлээн зөвшөөрнө.

## Данснаас хасах

Зээл, өрийн үнэт цаасыг нөхөх бодитой хэтийн төлөв байхгүй чед (хэсагчилсан эсхүл бүрэн хэмжээгээр) данснаас хасдаг. Зээлдэгч нь данснаас хасах дүнт төлөхөд хангалттай мөнгөн гүйлгээг бий болгож чадах хөрөнгө, орлогын эх үүсвэргүй гэж банкнаас тодорхойлсон тохиолдолд энэ нь ихэвчлэн тохиолддог. Хугацаа хэтэрсэн төлөгдөх ёстой телбэрийг нөхөн төлөх банкны журмыг дагаж мөрдөх үүднээс данснаас хасагдсан санхүүгийн хөрөнгө нь хууль сахиулах үйл ажиллагаанд хамрагдах боломжтой хувьэр байдаг.

## 4.5 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, Монгол Улсын Төв банк дахь харилцах дансны үлдэгдэл болон богино хугацаанд бэлэн мөнгө болгон хөрвүүлэх боломжтой бусад банканд байршуулсан мөнгөн хөрөнгө, үүнд хугацаа нь 90 хоногийн дотор дуусгавар болох, тодорхой хэмжээний бэлэн мөнгө болгон хөрвөх боломжтой, үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэл багатай өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт заргээс бурдэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

## 4.6 Бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад банк нь бусад банканд янз бүрийн хугацаатай урьдчилгаа эсхүл хадгаламжийг байршиулдаг. Банканд олгосон тогтмол хугацаатай зээл, урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Тогтмол хугацаагүй урьдчилгаа, хадгапамжийг удирдлагаас тооцоолсон төлөх хугацааг үндэслэн хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийг үнэ цэнийн бууралтын алдагдлын нөөцийг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

## 4.7 Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө ба өр төлбөр

"Арилжааны хөрөнгө, өр төлбөр" гэдэг нь банк ойрын хугацаанд худалдах, эргүүлэн худалдаж авах зорилгоор худалдан авсан эсхүл бий болгосон, эсхүл богино хугацааны ашиг эсхүл байр суурь олж авах зорилгоор хамтран удирддаг багцын нэг хэсэг болгон эзэмшдэг хөрөнгө, өр төлбөр юм. Арилжааны хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр анх болон дараа үед хүлээн зөвшөөрөн, хэмжиж гүйлгээний зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг арилжааны цэвэр орлогын нэг хэсэг болгон ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк нь ердийн бизнесийн үйл ажиллагааны явцад гадаад валют, хөрөнгийн зах зээл дээр фьючерс, форвард, своп, опцион зэрэг терэл бүрийн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцэлд ордог. Ийм санхүүгийн хэрэглүүрийг арилжааны зорилгоор эзэмшдэг ба санхүүгийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрөх бодлогын дагуу анх хүлээн зөвшөөрч, дараа үед бодит үнэ цэнээр нь үнэлдэг. Бодит үнэ цэнийг тогтсон зах зээлийн үнэ эсхүл үнийн загварт үндэслэн тухайн хэрэглүүрийн одоогийн зах зээлийн ба герээний үнэ болон бусад хүчин зүйлсийг харгалзан тооцоолдог. Деривативуудыг бодит үнэ цэнэ нь зөрөөг байвал хөрөнгөөр бүртгэх ба сөрөг бол өр төлбөрөөр бүртгэнэ.

## 4.8 Зээл ба урьдчилгаа

Зээл ба урьдчилгаа нь банкаас авлагыг арилжих зорилгогүйгээр шууд зээлдэгчид мөнгө олгох үед үүсдэг тогтмол буюу тодорхойлсон төлбөртэй санхүүгийн хөрөнгө юм.

Банкнаас олгосон тогтмол хугацаатай зээл нь бодит үнэ цэнэ дээр холбогдох ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрөгддэг. Бодит үнэ цэнэ нь зээлийн бодит үнэ цэнэтэй ойролцоо бус бол жишээ нь зээлийг зах зээлийн ханшаас доогуур үнээр олгосон тохиолдолд уг зүйлийн бодит үнэ болон зээлийн бодит үнэ цэнийн зөрүүг анх хүлээн зөвшөөрөх үеийн алдагдал гэж хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хөрөнгийн алдагдал гэж тусгана. Дараа үед зээлийн дансны үнийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хэмжинэ. Тогтмол хугацаагүй харилцагчдад олгосон зээлийг хүлээгдэж буй хугацаанд үндэслэн үр ашигт хүүгийн аргаар бүртгэнэ. Харилцагчдад олгосон зээлийг үнэ цэнийн бууралтын алдагдлын хасагдууллыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ.

## 4.9 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

Санхүүгийн байдлын тайлангийн "өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт" нь дараах байдлаар байна:

- Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөгдхөх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт; үүнийг анхдагч бодит үнэ цэнэ дээр шууд нэмэгдсэн ажил гүйлгээний зардлыг нэмж анхлан бүртгэх ба, дараа үед үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ;
- Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар зайлшгүй хэмжигдэх өрийн болон емчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт; өдгөөрийг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр тооцож, шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө;

- Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх ерийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт; болон
- Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт.

БҮЦБДО-р хэмжсэн өрийн хэлбэрээрх үнэт цаасны хувьд хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн нэгэн адил ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дараахаас бусад тохиолдолд олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод тусгана:

- Үр ашигт хүүгийн аргыг ашигласан хүүгийн орлого;
- Хүлээгдэж буй зээлийн алдагдал болон буцаалт
- Гадаад валютын ханшийн ашиг, алдагдал.

БҮЦБДО-д бүртгэсэн өрийн үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.

Банк нь арилжааны зорилгоор бус өмчийн хэрэглүүрт оруулсан тодорхой хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн. Энэ нь хэрэглүүр дээр анх хүлээн зөвшөөрсний үндсэн дээр бүртгэсэн ба буцаах боломжгүй юм.

Тус өмчийн хэрэглүүрийн олз, гарзыг хэзээ ч ашиг, алдагдалд дахин ангилдаггүй ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөггүй. Ногдол ашигийг хөрөнгө оруулалтын зардлын зарим хэсгийн нөхөлтэд тодорхой илэрхийлэхгүй бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ба энэ тохиолдолд тэдгээрийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг данснаас хассан хөрөнгө оруулалтын хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

#### 4.10 Репо хэлцэл ба урвуу репо хэлцэл

Борлуулах болон буцаан худалдан авах гэрээг ("repo") хэлцлийг баталгаатай санхүүгийн хэлцэл гэж үнэ. Худалдах, буцаан худалдан авах гэрээний дагуу худалсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд бүртгэх ба хэрэв шилжүүлэгч нь гэрээний дагуу борлуулах, дахин барьцаалах эрхтэй бол борлуулах, буцаан худалдан авах гэрээгээр барьцаалсан үнэт цаас гэж дахин ангилж, тусдаа тайлан баланс гаргана. Холбогдох өр төлбөрийг санхүүгийн байгууллагын болон харилцагчийн байршуулсан хөрөнгө гэж толилуулна.

Буцаан худалдах гэрээний дагуу ("урвуу репо") худалдан авсан үнэт цаасыг бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө, эсхүл харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа гэж бүртгэх ба санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөгддөггүй. Борлуулах ба буцаан худалдан авах үнийн зөрүүг хүү гэж тооцож, үр ашигт өгөөжийн аргыг ашиглан репо хэлцлийн хугацаанд хуримтлуулан тооцно.

Буцаан худалдах гэрээгээр худалдаж авсан хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдсан тохиолдолд үнэт цаасыг буцааж өгөх үүргийг арилжааны өр төлбөр гэж бүртгэж, бодит үнэ цэнээр нь үнэлнэ.

#### 4.11 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Түрэсийн орлого олох /эсхүл капиталын зорилгоор взамшиж буй хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгийг анх хэлцлийн зардлыг оролцуулан өртгөөр нь хэмжинэ. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа үед хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгийг НББОУС 40-ын дагуу түүхэн өртгийн загвараар хэмжинэ.

Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн үеийн ашиг, алдагдалд оруулна.

#### 4.12 Түрээс

Аливаа шинэ гэрээний хувьд гэрээ нь түрэсийн гэрээ мөн эсэхийг Банк авч үздэг. Түрэсийг "хөрөнгийг (үндсэн хөрөнгө) тодорхой хугацааны туршид төлбөр төлж ашиглах эрхийг шилжүүлэх гэрээ буюу гэрээний нэг хэсэг" гэж тодорхойлдог. Энэхүү тодорхойллыг хэрэгжүүлэхийн тулд Банк гэрээ нь дараах гураван үндсэн үнэлгээг хангаж байгаа эсэхийг үнэлдэг:

- Гэрээ нь тодорхойлогдсон хөрөнгийг тусгасан байгаа бөгөөд энэ нь гэрээнд тодорхой заасан эсхүл тухайн хөрөнгийг банкны мэдэлд өгөх үед тодорхойлогдсон байдлаар шууд бусаар тусгасан,
- Банк нь гэрээнд заасан эрхийн хүрээнд ашиглалтын хугацаанд тухайн хөрөнгийг ашигласнаас гарсан бүх эдийн засгийн үр өгөвжлийг бүрэн авах эрхтэй,
- Банк нь тодорхойлсон хөрөнгийг ашиглалтын бүх хугацаанд ашиглахад удирдах эрхтэй. Банк нь ашиглалтын хугацаанд уг хөрөнгийг хэрхэн, ямар зорилгоор ашиглахыг удирдах эрхтэй эсэхийг үнэлнэ.

### *Түрээс хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

#### *Банк түрээслэгчийн хувьд*

Түрээс эхлэх өдрөөр банк нь санхүүгийн байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхийн хөрөнгийг өргөөр нь хэмжих ба энэ нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилт, банкны зарцуулсан аливаа шууд зардал, түрээсийн хугацааны эцэст хөрөнгийг буулгах, нураахтай холбоотой тооцоолсон зардал болон түрээс эхлэх өдрөөс өмнө хийгдсэн урьдчилтгаа төлбөрийн нийлбэр юм.

Банк нь ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нехцэл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхийн хөрөнгөнд үнэ цэнэ буурах нехцэл бүрдсэн бол үнэ цэнийг бууруулна. Түрээсийн сайжруулалтыг шууд шугамын үндсэн дээр түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацаанаас богино хугацаанд капиталжуулж, элэгдүүлнэ.

Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо Банк нь ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүгийн төвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн төвшинг) ашиглан дискаунтилан тооцно.

Түрээсийн өр төлбөрийн тооцоололд тогтмол төлбөрүүд, индекс эсвэл ханш дээр сууринсан хувьсах төлбөрүүд, гарзэт хугацааны эцэст төлөх нь тодорхой болсон бусад төлбөрүүд хамаарна.

Дараа үеийн хэмжилтийн үед өр төлбөр нь төлсөн төлбөрөөр буурч, тооцоолсон хүүгээр өснө. Өр төлбөр нь гэрээлсэн тогтмол төлбөрт өөрчлөлт орох үед болон аливаа бусад төлбөрийн тооцоололд өөрчлөлт орох үед дахин тооцоологдоно.

Түрээсийн өр төлбөр дахин тооцоологдоход түүнд хамаарах ашиглах эрхийн хөрөнгөнд тохируулга хийгдэх ба хэрэв ашиглах эрхийн хөрөнгө үлдэгдэлгүй болсон бол ашиг алдагдалд тохируулга хийгдэнэ.

Банк нь ботино хугацааны түрээс, бага өртөг бүхий хөрөнгийн түрээсийг өөрийн практик туршлагад үндэслэн ангилан бүртгэнэ. Тэдгээр хөрөнгүүдийг ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөр гэж бүртгэхгүй ба харин холбогдо төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Банк нь гадаад янз бурийн эх үүсвэрээс авсан зээлдээ дүн шинжилгээ хийх замаар зээлийн өсөн нэмэгдэх хүүг тодорхойлж, түрээсийн нехцэл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг тусган тодорхой зохицуулалт хийдаг.

Санхүүгийн байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд, түрээсийн өр төлбөрийг бусад өр төлбөрт тусгана.

#### *Банк түрээслүүлэгчийн хувьд*

Түрээслүүлэгчийн хувьд банк түрээсийг үйл ажиллагааны болон санхүүгийн түрээс гэж ангилдаг.

Түрээс нь үндсэн хөрөнгийг зазэмшихтэй холбоотой бүх эрсдэл, үр дүнг шилжүүлсэн тохиолдолд санхүүгийн түрээс гэж ангилагддаг бөгөөд бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээс гэж ангилагдана.

Түрээсийн эхлэх өдөр гэдэг нь түрээслэгч нь түрээсийн хөрөнгийг ашиглах эрхээ хэрэгжүүлэх эрхтэй болсон өдөр юм. Энэ нь түрээсийн гэрээг анх хүлээн зөвшөөрсөн өдөр юм. Санхүүгийн түрээсийг эхлүүлэх үед Банк түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь түрээсийн төлбөрийн авлагын хамгийн бага хэмжээ бөгөөд түрээсийн гэрээнд тусгатдсан хүүгийн хэмжээгээр дискаунталсан байна. Нийт хөрөнгө оруулалт болон түүний өнөөгийн үнэ цэнийн зөрүүг урьдчилж орсон санхүүгийн түрээсийн орлого гэж бүртгэнэ.

Санхүүгийн түрээсийн орлогыг санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын өгөөжийн тогтмол хувь хэмжээг тусгасан загварт үндэслэн хүлээн зөвшөөрдөг. Анхны шууд зардлыг түрээсийн авлагын анхны хэмжилтэд оруулсан.

Банк дуусгавар болсон түрээсийн гэрээгээр санхүүгийн түрээсийн хөрөнгийг зээмшилдээс авахдаа тухайн хөрөнгийг бодит бодит бодит үнэ цэнэ болон бараа материалын хорогдуулсан түүхэн өргтийн баагаар хэмждэг.

#### 4.13 Үнэт металл

Алт болон бусад үнэт металлыг бодит үнэ цэнэй ойролцоо Монголбанкны үнээр бүртгэж, Лондонгийн үнэт металлын зах зээлийн ханшийн дагуу үнэлнэ. Үнэт металлыг санхүүгийн байдлын тайлангийн бусад хөрөнгөд оруулна.

Санал болгож буй үнийн өөрчлөлтийг бусад орлого/зардлаар, үнэт металлын үйл ажиллагааны цэвэр олз/гарзаар бүртгэнэ.

#### 4.14 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүхэн өрттөөр нь хуримтлуулсан элэгдлийг хасаж бүртгэнэ. Түр гэж тооцогдохгүй нехцөл байдлын улмаас үндсэн хөрөнгийн нөхөгдөх үнэ нь дансны үнээс доогуур байвал, тухайн хөрөнгийг нехеж болох үнэ хүртэл нь бүртгэнэ.

Элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар тооцоолно. Дараах байдлаар элэгдлийн хувь хэмжээг тооцно:

	Ашиглалтын хугацаа ( жил)	Хувь
Байшин	40	2.5%
Компьютер	2	50.0%
Тээврийн хэрэгсэл	10	10.0%
Бусад үндсэн хөрөнгө	10	10.0%

Түрээсийн сайжруулалтыг шулуун шугамын аргаар түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацаанаас богино хугацаагаар капиталжуулж, элэгдүүлнэ. Баригдаж байгаа хөрөнгийг бодит зардлаас үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасаж тооцно. Барилгын ажил дууссаны дараа хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, дансны үнээр нь бүртгэнэ. Баригдаж байгаа хөрөнгийг ашиглалтад орох хүртэл элэгдэл тооцохгүй.

Засвар, үйлчилгээний зардлыг тухайн үеийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Их засварын зардлыг тухайн хөрөнгийг бий болсон үед болон хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан тохиолдолд дансны үнэд тусгана. Их засварын ажлыг холбогдох хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаагаар элэгдэл тооцно.

Орлогыг дансны үнэтэй харьцуулах замаар зарж борлуулсны олз, гарзыг тодорхойлох ба үйл ажиллагааны ашигт тусгана.

Газар болон барилгыг ойролцоогоор 3-5 жилийн дараа дахин үнэлдэг. Дахин үнэлгээний давтамж нь хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон тэдгээрийн дансны үнийн хооронд ихээхэн зөрүү гарсан тохиолдолд дахин үнэлгээ хийнэ. Дахин үнэлгээг үндсэн хөрөнгийн бүх ангилалд хийнэ.

Өмнө нь орлогын тайланд тусгагдсан ижил хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцаахаас бусад тохиолдолд, дахин үнэлгээний нэмэгдлийг балансын өмчийн хэсэг дэх үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцэд тусгагдсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцэд тооцно, энэ тохиолдолд есэлтийг орлогын тайланд хүлээн зөвшөөрнэ. Дахин үнэлгээний гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнэ.

Үндсэн хөрөнгийг ашиглахтай зэрэгцэн хөрөнгийн дахин үнэлсэн дүнгээр тооцоолсон элэгдлийн зөрүү, хөрөнгийн өртөгт үндэслэн тооцоолсон элэгдлийн зөрүүг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ

Үндсэн хөрөнгийг борлуулах, данснаас хассан тохиолдолд тухайн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцэд хамаарах үлдэгдэл бүхэлдээ хуримтлагдсан ашигт шилжинэ.

## 4.15 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөд компьютерын программ хангамж, лиценз болон бусад зүйлс орно.

Тус тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжинэ. Биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хуримтлагдсан хорогдол болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь бүртгэнэ. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг хязгаартай засвэл тодорхойгүй гэж үнэлдэг. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийг 1-ээс 10 жил хүртэлх эдийн засгийн ашигтай хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулах ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсан тохиолдолд үнэ цэнийн бууралтыг үнэлдэг. Хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн зэлгэдлийн хугацаа, аргачлалыг санхүүгийн жил бүрийн төгсгөлд хянадаг.

Хязгааргүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулдаггүй, харин жил бүр дангаар нь засвэл мянгэ үүсгэгч нэгжийн түвшинд үнэ цэнийн бууралтыг шалгадаг. Хязгааргүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг жил бүр хянадаг бөгөөд энэ нь тодорхой бус ашиглалтын үнэлгээ зөвхөөр байгаа эсэхийг тодорхойлох болно.

Компьютерын программ хангамжийн засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг гарсан үед нь зардалд бүртгэнэ. Программ хангамж хөгжүүлэх зардлыг (шинэ засвэл мэдэгдэхүйц сайжруулсан программ хангамжийн дизайн, туршилттай холбоотой) зөвхөн банк программ хангамжийг ашиглах, худалдахад бэлэн болгох техникийн боломжтойг нотлон харуулж чадсан тохиолдолд л биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч, иж бүрэн байдал, тухайн хөрөнгийг ашиглах, борлуулах чадвар, тухайн хөрөнгө нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг хэрхэн бий болгох, дуустах нөөц боломж, бүтээн байгуулалтын явцад гарсан зардлыг найдвартай хэмжих чадвартай болно. Программ хангамж боловсруулах бусад зардлыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрдөг.

## 4.16 Өмчлөх бусад хөрөнгө

Банкны бодлого нь буцаан өмчилсөн хөрөнгийг дотоод үйл ажиллагаанд хамгийн сайн ашиглаж болох уу, засвэл зарах ёстой эсэхийг тодорхойлоход оршино. Дотоод үйл ажиллагаанд ашиг тустай гэж тодорхойлсон хөрөнгийг эргүүлэн авсан үнэ засвэл баталгаажсан анхны хөрөнгийн дансны үнээс бага багаар нь холбогдох хөрөнгийн ангилалд шилжүүлнэ. Худалдах нь илүү тохиromжтой гэж тодорхойлсон хөрөнгийг Банкны бодлогын дагуу эргүүлэн худалдан авах бодит үнэ цэнээр нь (хэрэв санхүүгийн хөрөнгө бол) болон санхүүгийн бус хөрөнгийг борлуулах өртгийг хассан бодит үнэ цэнээр нь худалдах зориулалттай хөрөнгө рүү шилжүүлнэ.

Тодорхой нехцөл байдалд хугацаа хэтэрсэн зээлийг хурааж авсны дараа хөрөнгийг буцаан авдаг. Буцааж авсан хөрөнгийг өөрийн артг болон бодит үнэ цэнийн ба борлуулах зэрдлыг хассанаар үнэлнэ.

## 4.17 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хойшлогдсон татвараас бусад санхүүгийн бус хөрөнгийг тайлант өдөр бүр үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дун нь борлуулалтын зардал болон ашиглалтын үнэ цэнийг хассан үнийн дунгээс их байх болно. Ашиглалтын үнэ цэнийг үнэлэхдээ мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн өнөөгийн зах зээлийн үнэлгээ болон хөрөнгийн эрсдэлийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээг ашиглан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг өнөөгийн үнэ цэнэд нь хямдруулна.

Бусад хөрөнгөөс ихээхэн хамааралгүй мөнгөн орлого үүсгэдэггүй хөрөнгийн хувьд нөхөгдх дүнг тухайн хөрөнгө хамаарах бэлэн мянгэ үүсгэгч нэгжээр тодорхойлно. Хөрөнгийн дансны үнэ засвэл түүний мянгэ үүсгэгч нэгжийн үнэ нөхөгдх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн бус хөрөнгийн бүх үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрч, нөхөн сэргээгдэх дүнг тодорхойлоход ашигласан тооцоонд өөрчлөлт орсон тохиолдолд л буцаана. Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн хөрөнгийн үнэ нь элэгдэл, хорогдлыг хассан дансны үнээс хэтрээгүй тохиолдолд л буцаан олгогдоно.

## 4.18 Зээл

Төв банк болон Засгийн газарт төлөх ёстой зээл, санхүүгийн байгууллагад төлөх дүн, харилцагчдад төлөх дүн, гаргасан өрийн үнэт цаас, хоёрдогч өрийг шууд хассан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч, энэ нь

гүйлгээний зардалд шууд хамаарал нь бага байна. Зээлүүдийг анх хүлээн зөвшөөрсний дараа үр ашигтай хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Олз, алдагдлыг өр төлбөрийг данснаас хассан, түүнчлэн хорогдуулах үйл явцаар дамжуулан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

#### 4.19 Санхүүгийн баталгаа ба зээлийн үүрэг

"Санхүүгийн баталгаа" гэдэг нь өрийн хэрэгслийн нөхцэлийн дагуу тодорхой хариуцагч төлбөрөө төлөөгүйгээс учирсан хохирлыг зээмшигчид нөхөн төлөхийн тулд Банкнаас тодорхой төлбер хийхийг шаарддаг гэрээ юм. "Зээлийн үүрэг" гэдэг нь урьдчилан тогтоосон нөхцелүүдийн дагуу ээзл олгох хатуу үүрэг амлалт юм.

Гаргасан санхүүгийн баталгаа эсвэл зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй ээзл олгох амлалтыг эхлээд бодит үнэ цэнээр нь үнэлдэг. Дараа нь тэдгээрийг СТОУС 9-ийн дагуу тодорхойлсон алдагдлын нөөц ба анх хүлээн зөвшөөрсэн дүнгээс СТОУС 15-ын зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрсөн орлогын хуримтлагдсан дүнг хасаж тооцсон дүнгээс хамгийн их хэмжээгээр хэмжинэ.

Санхүүгийн баталгаа, зээлийн амлалтаас үсэх өр төлбөрийг эрсдэлийн санд тусгана.

#### 4.20 Нөөц

Банк өнгөрсөн үйл явдлын үр дүнд одсогийн хууль эрх зүйн болон бүтээмжтэй үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөвийг агуулсан эх үүсварийн гадаш ургал шаарддагдах, үүргийн дүнг найдвартай тооцоолох боломжтой тохиолдолд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

#### 4.21 Өмч

##### Хувьцаат капитал

Энгийн хувьцаа болон эргүүлэн авах боломжгүй давуу эрхийн хувьцааг ногдол ашиг гэж ангилдаг. Бизнесийн нэгдлээс бусад шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой гадаад эардлыг өөрийн хөрөнгийн орлогоос хасалт болгон харуулна. Хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнийг гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан тохиолдолд нэмэлт төлсөн капитал гэж хүлээн зөвшөөрнө.

##### Нэмж төлөгдсөн капитал

Хувьцааны урамшуулалт хувьцаа гаргаснаас авсан аливаа урамшуулал багтана. Хувьцаа гаргахтай холбоотой хэлцлийн аливаа зардлыг хувьцааны урамшууллаас хасна.

##### Хуримтлагдсан ашиг

Одоогийн болон өмнөх үеийн хуримтлагдсан ашигийг оруулна.

##### Халаасны хувьцаа

Банк Банкны хувьцааг худалдан авах тохиолдолд төлсөн төлбөрийг орлогын албан татвар хассан гүйлгээний зардлыг оруулан цуцлах буюу дахин гаргах хүртэл нийт өөрийн хөрөнгөөс мөнгөн сангийн хувьцаа болгон хасна. Ийм хувьцааг дараа нь худалдсан эсвэл дахин гаргасан тохиолдолд хүлээн авсан төлбөрийг өөрийн хөрөнгөд оруулна. Мөнгөн сангийн хувьцааг жигжээн дундаж өртгөөр бүртгэнэ.

##### Ногдол ашиг

Ногдол ашигийг тайлангийн өдрөөс өмнө буюу тайлангийн өдөр зарласан тохиолдолд л өр төлбөр гэж хүлээн зөвшөөрч, тайлангийн өдөр өөрийн хөрөнгөөс хасаж тооцино. Ногдол ашигийг тайлангийн өдрөөс өмнө санал болгосон эсвэл тайлангийн өдрөөс хойш санал болгосон буюу зарласан боловч санхүүгийн тайлан гаргах зөвшөөрел олгохоос өмнө тодруулна.

## **Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл**

Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдлийг барилга байгууламжийн бодит үнэ цэнийн өсөлтийг бүртгэхэд ашигладаг бөгөөд ийм бууралт нь өмнө нь өөрийн хөрөнгөд хүлзэн зөвшөөрөгдсөн ижил хөрөнгийн өсөлттэй холбоотой хэмжээгээр буурдаг.

**БҮЦБДО-д илэрхийлэх үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөц**  
Энэхүү нөөц нь хөрөнгө оруулалтын үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бодит үнэ цэнээр бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэдэг.

## **5 Голлох нягтлан бodoх бүртгэлийн тооцоолол ба үнэлэмж**

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас бодлого хэрэгжүүлэх, тайлагнасан хөрөнгө, ер төлбөр, орлого, зардлын хэмжээнд нөлөөлөхүйц дүгнэлт, тооцоолол, таамаглал гаргахыг шаарддаг. Тооцоолол болон холбогдох таамаглалууд нь тухайн нэхцэл байдалд үндэслэлтэй гэж үзэж буй түүхэн туршлага болон бусад янз бурийн хүчин зүйлээ дээр үндэслэсэн бөгөөд үр дүн нь бусад эх сурвалжаас тодорхой бус хөрөнгө, ер төлберийн үнэ цэнийн талаарх дүгнэлт гаргах үндэс суурь болдог. Хэдийгээр эдгээр тооцоолол нь одоогийн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэгт үндэслэсэн боловч эцсийн дундээ бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Тооцоолол болон үндсэн таамаглалыг байнга хянаж байдаг. Нягтлан бodoх бүртгалийн тооцоололд хийсэн засварыг тооцооллыг засварласан тайлант хугацаанд болон ирээдүйд нөлөөлсөн аливаа хугацаанд хүлзэн зөвшөөрнэ.

### **5.1 Үнэлэмж**

**Санхүүгийн хөрөнгийн ангилал:**

Банк нь тухайн хөрөнгийг эзэмшиж буй бизнесийн загварыг үнэлж, санхүүгийн хөрөнгийн гэрээний нэхцэл нь зөвхөн үндсэн төлбэрийн үлдэгдэл төлбөр болон хүүгийн төлбөр мөн эсэхийг үнэлдэг (Тодруулга 4.4.2-г үзнэ үү).

#### **Зээлийн хулээгдэж буй алдагдлыг тооцоолох шалгуурыг бий болгох**

Банк нь анх хүлзэн зөвшөөрөгдсөнөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэхийг тодорхойлох шалгуурыг тогтоож, хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтэд ирээдүйн мэдээллийг тусгах аргачлалыг тодорхойлж, хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихэд ашигласан загваруудыг сонгож, баталдаг.

### **5.2 Төсөөлөл ба тооцооллын тодорхойгүй байдал**

**Бодит үнэ цэнийн хэмжилт**

Удирдлага нь санхүүгийн хэрэгсал (зах зээлийн идэвхтэй үнийн санал байхгүй тохиолдолд) болон санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоходо үнэлгээний аргыг ашигладаг. Үүнд зах зээлд оролцогчид уг хэрэгслийг хэрхэн үнэлж байгаатай нийцэн тооцоолол, таамаглалыг боловоруулах шаардлагатай. Удирдлага нь аль болох ажиглагдах боломжтой өгөгдэл дээр үндэслэн таамагладаг боловч энэ нь үргэлж боломжтой байдаггүй. Энэ тохиолдолд удирдлага хамгийн сайн мэдээллийг ашигладаг. Тооцоолсон бодит үнэ цэнэ нь тайлagnalын өдөр бие даасан гүйлгээнд хүрэх бодит үнээс ялгаатай байж болно.

#### **Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа**

Үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжийн ашиглалтын үнэлгээ нь ижил төстэй хөрөнгөтэй холбоотой туршлага дээр үндэслэн дүгнэлт хийсний үр дүн юм. Ирээдүйн эдийн засгийн үр өгөвжлийг эд хөрөнгөд тусгаж, голчлон ашиглалтын хамт хэрэглэдэг. Удирдлага нь үлдэгдэл ашиглалтын хугацааг хөрөнгийн одоогийн техникийн нэхцэл, тооцоолсон хугацааны дагуу үнэлдэг бөгөөд энэ хугацаанд Банк ашиг хүртэнэ гэж тооцдог. Үндсэн ашиглалтын хугацааг үнэлэхдээ дараах үндсэн хүчин зүйлсийг харгалзан үздэг:

ашиглалтын хүчин зүйл, засвар үйлчилгээний хетэлберөөс хамааран хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт, энэ нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс үүдэлтэй элэгдэл юм.

### *Түрээсийг сунгах сонголт*

Банк түрээсийн хугацааг сунгах боломжтой болсон үед удирдлага нь сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэй эсэхийг тодорхойлохын тулд өөрийн дүгнэлтийг ашигладаг. Удирдлага нь түрээсийн хугацааг тодорхойлоход нь туслахын тулд, өмнөх практик болон сунгах сонголтыг аваагүй тохиолдолд хөрөнгийг өөрчлөхөд гарах аливаа зардлыг багтаасан бүх баримт, нөхцөл байдлыг харгалзан үздэг.

### *Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралт*

Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг анх хүлээн зөвшөөрч, хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтэд тусгаснаас хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн эсэх, түүнчлэн нөхцөдөх мөнгөн гүйлгээг тооцлооход ашигласан гол таамаглалуудыг үнэлдэг. (Тодруулга 4.4.6 г үзнэ үү)

## **6 Хүү болон түүнтэй адилтгах орлого, зардал**

<b>Мянган төгрөгөөр</b>	<b>2022 он</b>	<b>2021 он</b>
<i>Үр ашигт хүүгийн өргөчлөлтөөр бодсон хүүийн орлого</i>		
Харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа	297,887,697	284,110,046
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэгдэх өрийн хэрэгсэл	68,363,362	66,874,415
Балэн менё ба Монголбанк дахь харилцах	10,358,274	4,717,491
Свопын хүүгийн орлого	7,047,692	2,957,016
Бусад банк ба санхүүгийн байгууллагын дахь харилцах, хадгаламж	5,638,178	227,926
Урвуу репо хэлцэл	165,858	27,112
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгсэл	6,684,430	4,586,182
	<b>396,145,491</b>	<b>363,500,188</b>
<i>Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого</i>		
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх өрийн хэрэгсэл	8,520,643	4,804,139
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайландаа бүртгэгдэх харилцагчад олгосон зээл ба урьдчилгаа	163,785	17,169,502
	<b>8,784,428</b>	<b>21,973,641</b>
<i>Нийт хүүгийн орлого</i>	<b>404,929,919</b>	<b>385,473,828</b>
Харилцагчдын харилцах, хадгаламж	(148,844,706)	(163,871,036)
Зээлээр авсан эх үүсвэр	(6,714,912)	(7,201,098)
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	(8,964,910)	(7,011,837)
Репо хэлцэл	(8,756,981)	(6,330,750)
Свопын хүүгийн зардал	(9,570,542)	(5,880,838)
Түрээсийн өглөгийн хүүгийн зардал (Тодруулга 24)	(7,572)	(344,962)
<i>Нийт хүүгийн зардал</i>	<b>(182,859,623)</b>	<b>(190,640,521)</b>
<i>Нийт цэвэр хүүгийн орлого</i>	<b>222,070,298</b>	<b>194,833,308</b>

2022 онд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайландаа бүртгэгдсэн өрийн хэрэгсэлд орж байгаа Засгийн газрын бонд нь 11,169,148 мянган төгрөг (2021: 8,312,960 мянган төгрөг) байна.

## 7 Төлбөр хураамжийн орлого, зардал

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
<b>Хураамж ба шимтээлийн орлого</b>		
Дансны үйлчилгээний шимтгэл, хураамж	8,750,354	8,549,438
Картын үйлчилгээний шимтгэл, хураамж	12,865,870	10,816,596
Цахим банкны үйлчилгээний шимтгэл, хураамж	9,748,506	7,331,789
Зээлтэй холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамж	2,297,112	1,775,743
Мянган гүйвуулга үйлчилгээний орлого	469,676	580,043
<b>Нийт хураамж, шимтээлийн орлого</b>	<b>34,132,518</b>	<b>29,053,607</b>
<b>Хураамж ба шимтээлийн зардал</b>		
Банкны үйлчилгээний хураамж	(3,535,927)	(2,799,309)
Картын гүйлгээний хураамж	(5,092,595)	(3,736,940)
Бусад шимтээлийн зардал	(199,891)	(182,382)
<b>Нийт хураамж, шимтээлийн зардал</b>	<b>(8,828,413)</b>	<b>(6,718,631)</b>
<b>Шимтгэл, хураамжийн цэвэр орлого</b>	<b>25,304,105</b>	<b>22,334,976</b>

## 8 Арилжааны цэвэр орлого

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Гадаад валютын цэвэр орлого	13,461,603	3,689,825
Өрийн үнэт цаас	-	306,816
<b>Нийт арилжааны цэвэр орлого</b>	<b>13,461,603</b>	<b>4,006,641</b>

Өрийн үнэт цаасны орлогод өрийн үнэт цаасны худалдан авах, худалдах арилжааны үр дүн, тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд болон холбогдох хүүгийн орлого, зардал орно. Гадаад валютын орлогод спот форвард болон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлцлээс бий болсон ашиг алдагдлууд орно.

## 9 Үйл ажиллагааны бусад (зардал)/ орлого

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Гадаад валютын арилжааны бус (гарз)/олз, цэвэр	(852,564)	(946,812)
Хураан авсан хөрөнгийн эрдээлийн санг буцаасны олз/гарз (Тодруулга 19)	(4,641,891)	(3,553,750)
Гэрээ өөрчилсний гарз, цэвэр (1)	-	(13,930,889)
Бусад (2)	2,935,149	889,698
<b>Нийт үйл ажиллагааны бусад (зардал) орлого</b>	<b>(2,559,306)</b>	<b>(17,541,753)</b>

(1) Тайлант жилд Монгол улсын засгийн газар Ковид-19-тэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийг хойшлуулахаар мэдээлсэн бөгөөд энхүү шийдвэр нь ямар нэгэн шалгуургүйгээр бүх ипотекийн орон сууцны зээл болон хэрэглээний зээлтэй зээлдэгчдэд хамааралтай. Үүнтэй холбоотойгоор, Банк нь 2021

оны 12 сарын 31- ний байдлаар гэрээний нэхцэл өөрчлөлтийн алдагдал болох 13.9 тэрбум төгрөгийг бүртгэсэн (2020: 8,2 тэрбум төгрөг)

(2) Банк нь ажилтнууддаа олгосон дамжлэг, тусlamжаас НДШ-ийг суутгаж, зардлаар хүлээн зөвшөөрсөн байсан ба тайлант хугацаанд буцааж, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

## 10 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын ашиг (алдагдал)

Тайлант жилд ашиг, алдагдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хэрэгслийн ЗҮЦХА (Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал)-ын нэмэгдэл болон буцаалт:

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (Тодруулга 13, 14)	130,254	5,295
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 16)	(2,866,859)	30,434,785
Хорогдуулсан өртөөр бүртгэх өрийн хэрэгсэл (Тодруулга 18)	(771,399)	1,234,614
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл (Тодруулга 18)	217,033	(39,428)
Бусад хөрөнгө (Тодруулга 19)	(866,822)	377,624
<b>Нийт үнэ цэнийн бууралтын алдагдал/буцаалт</b>	<b>(4,167,793)</b>	<b>32,012,890</b>

## 11 Ерөнхий удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Цалин, хөлс ба урамшуулал	71,481,651	54,004,638
Нийгмийн даатгалын шимтгэл	9,029,526	7,832,986
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 22)	13,183,381	13,147,220
Давтгалын хураамж	5,982,122	6,230,639
- Туршилтын хугацаатай олгосон зээл. Туршилтын хугацаанд (сайжруулалтын дараах хугацаа) зээлийн хугацаа хэтэрсэн эсхүл чанаргүй зээл болох тохиолдолд зээлийн эрсдэл нэмэгдсэн гэж үзнэ. Энэ тохиолдолд зээл нь 30 хоногоос дээш хугацаа хэтэрсэн эсхүл зээлийг төлөх шинж төлөвлүй байна.

## **Санхүүгийн байгууллагаад байршуулсан хөрөнгийн шалгуур**

Зээлийн байгууллага болон бусад санхүүгийн байгууллагад тавигдах шалгуурыг дараах байдлаар үзүүлэв. Зээлийн эрсдэлийн өсөлтийг тодорхойлох бүх шалгуур үзүүлэлтүүд ижил жинтэй байна.

- 30 хоног хугацаа хэтэрсэн. Хугацаа 30-аас дээш хоног хэтэрсэн нь зээлийн эрсдэл нэмэгдсэнийг илтгэнэ.
- Корреспондент болон харилцах дансны хувьд хугацаанаас 7 хоног хугацаа хэтрэлт. 7 хоногоос дээш хугацаа хэтрэх нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг илтгэнэ.
- Хугацаа хэтэрсэн - 30 хоногоос бусад. Тайлангийн өдөр 30 өдрөөс бага хугацаа хэтэрсэн хэдий ч сүүлийн 6 сарын хугацаанд хамгийн багадаа 60-аас дээш хоног хэтэрсэн нэг тохиолдол байвал зээлийн эрсдэл нэмэгдсэн гэж үзнэ.
- Хөндлөнгийн зээлжих эрсдэлийн онос/үнэлгээний түвшингийн өөрчлөлт. Энэ шалгуурын хувьд банкны үнэлгээг харгалzan үзнэ. Гурван том зээлжих үнэлгээний агентлагуудаас (Standard & Poor's, Moody's, Fitch) олгосон зээлийн үнэлгээ оноонд өөрчлөлт гарсан нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. S & P зэрэглэл B2 (S&P) (эсвэл Moody's, Fitch-тэй дүйцэхүйц) -ээс эхлан нэг түвшинд буурах бүрд зээлийн эрсдэлийн өсөлтийг харгалzan үздэг. Санхүүгийн байгууллага нь үнэлгээний агентлагт аж ахуйн наёжийн зэрэглэл тогтоодоггүй, Банк нь түүнтэй адилтгах дотоод үнэлгээний системгүй тохиолдолд тухайн улсын бүрэн эрхт байдлын зэрэглэлд тохирсон банкны дефолтыг харгалzan үзнэ.
- 12 сарын дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт. 12 сарын дефолтын магадлалын өөрчлөлтийг нь ашиглалтын хугацааны дефолтын магадлалын өөрчлөлтийн хүчин зүйл гэж үзнэ. Энэ нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. Банк дотоод зээлийн үнэлгээний системтэй үед энэ шалгуурыг ашиглана.
- Ашиглалтын хугацааны дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт. Ашиглалтын хугацааны дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. Банк нь дотоод зээлийн үнэлгээний системтэй үед энэ шалгуурыг ашиглана.
- Сүүлийн 12 сарын хугацаан дах дефолт (Шатлал 3'). Тайлангийн өдөр зээлийн үлдэгдэл дунг дефолт гэж ангилаагүй болон сүүлийн 12 сарын хугацаанд Шатлал 3-д дор хаяж нэг удаа орсон тохиолдолд зээлийн эрсдэл нэмэгдсэн гэж тооцино.

## **Хөрөнгө оруулалтын үнэт цаасны шалгуур**

Үнэт цаасны шалгуурыг дараах байдлаар үзүүлэв. Зээлийн эрсдэлийн нэмэгдэлтийг тодорхойлох бүх шалгуур үзүүлэлтүүд ижил жинтэй байна.

- 12 сарын дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт. 12 сарын дефолтын магадлалын өөрчлөлтийг нь ашиглалтын хугацааны дефолтын магадлалын өөрчлөлтийн хүчин зүйл гэж үзнэ. Энэ нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. Банк дотоод зээлийн үнэлгээний системтэй үед энэ шалгуурыг ашиглана.
- Ашиглалтын хугацааны дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт. Ашиглалтын хугацааны дефолтын магадлалтай холбоотой өөрчлөлт нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. Банк нь дотоод зээлийн үнэлгээний системтэй үед энэ шалгуурыг ашиглана.
- Хөндлөнгийн зээлжих эрсдэлийн онос/үнэлгээний түвшингийн өөрчлөлт. Энэ шалгуурын хувьд тухайн улсын зэрэглэлийг Засгийн газрын үнэт цаас, аж ахуйн наёжийн үнэт цаасны хувьд банкны зэрэглэлийг харгалzan үзнэ. Гурван том зээлжих эрсдэлийн үнэлгээний агентлагуудаас (Standard & Poor's, Moody's, Fitch) олгосон зээлийн үнэлгээ оноонд өөрчлөлт гарсан нь зээлийн эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна. S & P зэрэглэл B2 (S&P) (эсвэл Moody's, Fitch-тэй дүйцэхүйц) -ээс эхлан нэг түвшинд буурах үед зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг харгалzan үздэг. Үнэт цаас гаргагч нь үнэлгээний агентлагт банкны үнэлгээгүй, Банк нь түүнтэй адилтгах дотоод үнэлгээний системгүй тохиолдолд тухайн улсын бүрэн эрхийн зэрэглэлд тохирсон банкны дефолтыг харгалzan үзнэ.

## Бууралтын шатлалаас гарах шалгуур

Зээлийн эрдэл нэмэгдсэн зээхийг үнэлэхэд Банкнаас ашигладаг шалгуур үзүүлэлтүүдийн аль нь ч илрээгүй бол бол туршилтын хугацааг ашигласан зээлээс бусад тохиолдолд Шатлал 2-оос Шатлал 1 руу шилжүүлнэ.

### Зээлийн эрдэлийн зэрэглэл

Банк эрдэлд өртөх эрдэл тус бүрийг зээлийн эрдэлийн зэрэглэлд тооцдог бөгөөд энэ нь төлбөрийн чадваргүй болох эрдэлийг урьдчилан таамаглах боломжтой гэж тодорхойлсон төрөл бүрийн өгөгдэлд тулгуурлан, зээлийн туршлагатай үнэлээмжийг ашигладаг. Зээлийн эрдэлийн зэрэглэлийг чанарын болон тоон үзүүлэлтээр тодорхойлох ба (ундсэндээ хугацаа хэтэрсэн хоногоос шалтгаална: Хугацаа хэтрээгүй санхүүгийн хөрөнгийг өндөр зэрэглэл, 30-аас доош хоног хугацаа хэтэрсэн - стандарт зэрэг, 30-аас дээш хоног, 90 хоногоос доош хугацаа - стандартын бус буюу доод зэрэглэл болон 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн - чанаргүй зэрэг) хүчин зүйлүүд нь төлбөрийн үүргээ билэлүүлээгүй байх эрдэлийг илэрхийлдэг. Эдгээр хүчин зүйлүүд нь эрдэлийн шинж чанар болон зээлдэгчийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг.

Доорх хүснэгтэд Банкны үнэлгээний систем болон хөндлөнгийн үнэлгээний зураглалыг харуулав.

Дотоод үнэлгээ	Дотоод үнэлгээний тайлбар	Олон улсын хөндлөнгийн үнэлгээний агентлэгтийн (S&P) үнэлгээ
A	Маш сайн	AAA-A
B	Сайн	Baa-Ba
C	Хавийн бус	B
D	Эргэлзээтий	Caa-C
E	Muu	-
Үнэлгээгүй	Үнэлгээгүй	-
Тусгай үнэлгээгээр үнэ цэна буурсан	Тусгай үнэлгээгээр үнэ цэна буурсан	-

### Хамтад нь болон салангид үнэлгээ

Банк хүлээгдэж буй зээлийн алдагдлыг салангид тооцоолдог хөрөнгийн ангилалд дараах зүйлс багтана:

- Санхүүгийн хөрөнгийн зэрэглэлээс үл хамааран Шатлалт 3-д ангилагдах зээл
- Томоохон ба өвөрмөц эрдэлүүд
- Банкны хугацаа хэтэрсэн өр, репо хэлцлээр барьцаалсан үнэт цаас, хорогдуулсан өртөг/БҮЦБДО-р бүртгэх өрийн хэрэглүүр зэрэг мөнгөн сан, арилжаа болон банк хоорондын харилцаа
- Зээлд тулгуурласан өрийн бүтцийн өврчлелтийн үр дүнд анхны зээлийг данснаас хасаж, шинэ зээлийг хүлээн зөвшөөрсөн үед худалдан авсан болон үүссэн зээлийн үнэ цэнийн бууралт гэж ангилагдсан эрдэлүүд.

Эдгээр хөрөнгөд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг салангид тус тусад нь тооцоодогтүй ба банк нь доор тайлбарласны дагуу зээлийн эрдэлийн дундын шинж чанарт үндэслэн сегмент рүү бүлэглэнэ.

- Зээлийн төрөл (жишээлбэл, байгууллагын, моргайжийн, зээлийн карт, хэрэглээний зээл гэх мэт)
- Харилцагчийн төрөл (жишээлбэл, хувь хүн, хуулийн этгээд эсхүл салбарын төрлөөр),
- Барьцаа хөрөнгийн төрөл (жишээлбэл, эд хөрөнгө, авлага гэх мэт),
- Валют
- Бусад холбогдох шинж чанарууд.

### Дефолтын тодорхойлолт ба сайжруулалт

Зээлдагч гэрээний төлбөрөө төлөх хугацаа 90 хоног хэтэрсэн тохиолдолд Банк санхүүгийн хэрэглүүрийг хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолоходо Шатлал 3 (зээлийн үнэ цэнийн бууралт) гэж авч үзнэ.

Банк нь банк хоорондын төлбөрийг төлөгдөөгүй гэж үзэж, тусдаа гэрээнд тусгагдоны дагуу шаардлагатай төлбөрийг ажлын цаг дуусах хугацаанд барагдуулаагүй тохиолдолд яаралтай арга хэмжээ авдаг.

Харилцагч нь дефолт болсон эсэхийгүнэлэх чанарын үнэлгээний хүрээнд банк нь төлбөр хийх боломжгүй байгааг илтгэх яна бүрийн тохиолдлуудыг авч үздэг.. Ийм үйл явдал тохиолдоход Банк тухайн үйл явдал нь харилцагчийг дефолт болсон гэж үзэхэд хүргэх эсэхийг сайтар судалж үздэг ба иймээс хулээгдэж буй зээлийн алдагдлын тооцооллыг Шатлал 3 эсхүл Шатлал 2-ын аль тохирохоор үнэлнэ. Ийм үйл явдлууд дараах байдлаар байж болно:

- ер барагдуулах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах, түйцэтгэх буюу албадан түйцэтгэх,
- зээлдэгчийн тусгай зөвшөөрлийг цуцалсан,
- үндсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлдэгч нь хамтран хариуцагч байх,
- нэг эрсдэл дээр олон дахин бутцийн өөрчлөлт хийх,
- зээлдэгч тогтвортой, хангалттай мэнген гүйлгээг бий болгох ирээдүйн чадварын талаар үндэслэлтэй санаа зовник байгаа бол,
- зээлдэгчийн нийт хөшүүргийн түвшин мэдэгдэхүйц нэмэгдсэн эсвэл хөшүүргэг ийм өөрчлөлт хийх үндэслэлтэй хүлээлт байгаа; алдагдлын улмаас тайлант хугацаанд өрийн хөрөнгө 50%-иар буурсан;
- өрийн үйлчилгээний хамрах харьцаа нь өрийн тогтвортой байдлыг хангахгүй байгааг харуулж байна
- гол үйлчлүүлэгч эсвэл түрээслэгчээ алдах,
- холбогдсон харилцагч дамжуурлаа зарласан,
- материалыг хэсэгтэй бүтцийн өөрчлөлт хийх (цэвэр өнөөгийн үнэ цана (NPV) алдагдал),
- зээлийн байгууллага эсвэл консорциумын удирдагч дамжуурал/төлбөрийн чадваргүй болох ажиллагааг хэлүүлсэн

Банкны бодлого нь санхүүгийн хэрэглүүрийг "сайжруулсан" гэж үзэх ба иймээс дор хаяж турван сар дараалан үндсэн шалгуурын аль нь ч байхгүй тохиолдолд Шатлал 3-аас гаргахаар дахин ангилдаг. Сайжруулалтын дараа хөрөнгийг Шатлал 2- эсхүл Шатлал 1 гэж ангилж эсэх нь сайжруулалтын үеийн зээлийг шинэчилсэн зэрэг болон энэ нь анхдагч хүлээн зөвшөөрөлттэй харьцуулахад зээлийн эрдэл нэмэгдсэнийг харуулж байгаа эсэхээс хамаарна. Банкны хулээгдэж буй зээлийн алдагдлыг "сайжруулах" шалгур нь чанаргүй эрсдэлийн 12 сарын шаардлагаас бага зэрэгхатуу чанга байна.

### Зээлд өөрчлөлт оруулах

Зарим тохиолдолд Банк нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийг даван туулахад нь туслах үүднээс барьцааны хөрөнгийг зэмших, хураахыг албадахаас илүүгэйгээр зээлийн анхны нэхцэлдэв хөнгөлөлт үзүүлж, өөрчлөлт оруулдаг. Зээлдэгчийн одоогийн болон хулээгдэж буй санхүүгийн хүндрэлийн үр дүнд ийм хөнгөлөлт, өөрчлөлт олгогдсон тохиолдолд банк зээлийг хүчингүйд тооцдог бөгөөд хэрэв зээлдэгч санхүүгийн хувьд эрүүл байсан бол Банк үүнийг зөвшөөрөхгүй байсан. Санхүүгийн хүндрэлийн үзүүлэлтүүд нь гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл Зээлийн эрсдэлийн хэлтсээс гаргасан томоохон асуудлуудыг багтаадаг. Тэвчээртэй байх нь төлбөрийн зохицуулалтыг сунгах, зээлийн шинэ нэхцэлийг тохиролцох зэрэг байж болно. Нэхцэлүүдийг дахин тохиролцсоны дараа аливаа үнэ цэнийн буураалтыг нэхцэлийг өөрчлөхөөс өмнө тооцсон анхны үр ашигт хүүгийн аргыг ашиглан хэмжинэ. Ирээдүйн төлбөрүүд гарах магадлалыг баталгаажуулахын тулд төлөгдөөгүй зээлийг хянах нь Банкны бодлого юм.

Шатлал 2 ба Шатлал 3-ын хоорондох ангилал болон үл хүлээн зөвшөөрөх шийдвэрийг тохиолдол тус бүрээр тодорхойлно.

Банк нь "сайжруулах" хугацааг хулээнсээс хойшиг 12 сарын хугацаа гэж тодорхойлдог ба энэ хугацаа нь чанаргүй эрсдэлтэй холбостой байдаг. Хулээлцэсний дараа санхүүгийн хүндрэлийг шууд тодорхойлох боломжгүй байдаг тул зээлийг үр дүнтэй төлөх эсэхийг тодорхойлохын тулд "сайжруулах" хугацааг ашиглах шаардлагатай. Бүх чанаргүй зээлүүд нь зээлийн төлөв байдлыг үл харгалзан (хугацаа хэтэрсэн өдөр гэх мэт) хүлээнэх хугацаа дууссаны дараа Шатлал 3-д үлдэх ёстой.

Банк нь туршилтын хугацааг "сайжруулах" хугацаанаас хойшиг 24 сарын хугацаа гэж тодорхойлдог бөгөөд энэ хугацаа нь нехен төлбөрийн эрсдэлд (ямар ч хөнгөлөлтийн хугацаа орохгүй) хамаарна. Хөрөнгийг хугацаагүй эрсдэл гэж ангилсан бол хамгийн багадаа 24 сарын туршилтын хугацаанд үлдэнэ.

Зээлийг үл хамаарах ангилалд оруулахын тулд харилцагч дараах бүх шалгуурыг хангасан байх ёстой:

- Бүх зээлийг хэвийн гэж үзэх ёстой
- Гэрээг хэвийн гэж үзсэн өдрөөс хойш хоёр жилийн туршилтын хугацаа өнгөрсөн
- Туршилтын хугацааны хагасаас доошгүй хугацаанд үндсэн зээл эсвэл хүүгийн үлдэгдлийг тогтмол төлсөн байх.
- Харилцагч нь 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн зээлийн гарзагүй.

Хэрэв их хэмжээний өөрчлөлт оруулсан бол Тодруулга 4.4.4-т тайлбарласны дагуу зээлийг данснаас хасна.

### Дефолтын магадлал (PD)

Дефолтын магадлал нь зээлдэг санхүүгийн үүргээ дараагийн 12 сарын хугацаанд (12 сарын - хүлээгдэж буй зээлийн алдагдал) эсвэл үүргийн үлдсэн хугацаанд (ашиглалтын хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдал) биелүүлэхгүй байх магадлалыг илрэхийлдэг. Ашиглалтын хугацааны дефолтын магадлалыг одоогийн 12 сарын дефолтын магадлал руу төлөх хугацааны профайлыг оруулах замаар боловсруулдаг. Төлөх хугацааны профайл нь зээлийн ашиглалтын хугацаанд анх хүлээн зөвшөөрөгдхө үеэс эхлэн багцын дефолт хэрхэн үүсдэгийг хардаг. Төлөх хугацааны профайл нь ажигласан түүхэн өгөгдөл дээр үндэслэсэн бөгөөд багц болон зээлийн зэрэглэлийн хүрээн дэх бүх хөрөнгийн хувьд, ижил байна гэж үздэг. Үүнийг түүхэн шинжилгэээр дэмждэг.

### Дефолт болох алдагдал (LGD)

Дефолт болох алдагдал (LGD)-ыг дефолтоос хойш нөхөн сэргээхэд нөлөөлөх хүчин зүйлс дээр үндэслэн тодорхойлно. Эдгээр нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран өөр өөр байдаг.

- Барьцаатай бүтээгдэхүүний хувьд энэ нь үндсэндээ барьцаа хөрөнгийн төрөл болон төлөвлөсөн барьцаа хөрөнгийн үнэ цэнэ, албадан борлуулсны улмаас зах зээл/дансын үнэд гарсан түүхэн хөнгөлөлт, эргүүлэн авах хугацаа болон ажиглагдсан нөхөн сэргээх зардалд үндэслэдэг.
- Барьцаагүй бүтээгдэхүүний хувьд дефолт болох алдагдлыг ихэвчлэн өөр өөр зээлдэгчдийн нөхөн төлбөрийг хязгаарлагдмал ялгаатай байдлаас шалтгаалан бүтээгдэхүүний түвшинд тогтоодог. Эдгээр дефолт болох алдагдалд өөрөөтөөр өөрийн борлуулалт, үнэ зэрэг цуглуулах стратеги нөлөөлдөг.

### Дефолт болох үеийн үлдэгдэл (EAD)

12 сарын болон ашиглах хугацааны Дефолт болох үеийн үлдэгдэл (EAD)-г хүлээгдэж буй төлбөрийн профайл дээр үндэслэн тодорхойлдог бөгөөд энэ нь бүтээгдэхүүний төрлөөс хамаарч өөр өөр байдаг.

- Гэрээний нөхцөлтэй бүтээгдэхүүний хувьд энэ нь зээлдэгчийн 12 сар эсхүл ашиглалтын хугацаанд төлөх гэрээний эргэн төлөлтэд үндэслэдэг. Үүнийг мөн зээлдэгчийн хүлээгдэж буй илүү төлбөрт тохируулна. Эрт төлөлт/дахин санхүүжилтийн таамаглалыг мөн тооцоололд тусгасан болно.
- Эргэлтийн бүтээгдэхүүний хувьд төлбөрийн үлдэгдлийг тооцож, "зээлийн хөрвүүлэх хүчин зүйл"-ийг нэмснээр дефолтын үеийн эрсдэлийг урьдчилан таамаглаж байгаа бөгөөд энэ нь үлдэгдэл хязгаарын хүлээгдэж буй бууруулах боломжийг опгодог. Эдгээр таамаглалууд нь банкны сүүлийн үеийн дефолтын өвгөдөл дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бүтээгдэхүүний төрөл болон одоогийн хязгаарын ашиглалтын хүрээнээс хамаарч өөр өөр байна.

### Хэтийн төлөөийн мэдээлэл

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцох аргын тоймыг Тодруулга 4.7.6 дахь тооцоолол, таамаглалд тусгасан. Бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангахын тулд Банк нь гуравдагч талын эх сурвалжаас (ДБ, МБ, Засгийн газар гэх мэт) ашигласан өгөгдлийг авдаг. Макро здийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг бий болгсхын тулд банк сонгосон макро здийн засгийн хүчин зүйлс болон урьдчилан таамаглалсан олон хувилбарт (суурь, всех ба серөг) жинг тодорхойлдог. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын макро здийн засгийн тохируулгыг тооцоолохын тулд Банк өөрийн загварт здийн засгийн орц болгон өргөн хүрээний урьдчилсан мэдээллийг ашигладаг, Үүнд:

- ДНБ-ий өсөлт/бууралт
- ДНБ
- Гадаадаас цэвэр ургсал шилжүүлэг
- Ажилгүйдэл
- Банкны чанаргүй зээлийг нийт зээлд харьцуулах
- Худалдааны өсөлт
- Аж үйлдвэрийн өсөлт
- Барилгын өсөлт
- Хөдөө аж ахуйн өсөлт
- Валютын албан ёсны ханш
- Инфляц
- Үл хөдлөх хөрөнгийн үнэ (Улаанбаатар дах дундаж үнэ) (зөвхөн ашигласан үзүүлэлтүүдийг үлдээнэ үү)

### 37.1.2 Барьцаа болон бусад зээлийн нэмэлт материал

Шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээ, төрөл нь зээлийн эрсдэлийн үнэлгээнээс хамаарна. Барьцаа хөрөнгийн төрөл бүрийн хүлээн зөвшөөрдгэх байдал, үнэлгээг хамарсан удирдамжууд байдаг.

Авсан барьцааны үндсэн терпүүд нь дараах байдалтай байна:

- Үнэт цаасны зээл олгох болон урвуу репо хэлцэл, балэн мөнгө эсхүл үнэт цаас
- Арилжааны зээл, үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, дансны авлага, онцгой тохиолдолд засгийн газрын баталгаа
- Орон сууц болон бусад барьцаа хөрөнгийн хөрөглээний зээл
- Орон сууцны үл ипотек

Удирдлага нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг хянаж, үндсэн гэрээний дагуу нэмэлт барьцаа шаардана.

Банк санхүүгийн ямар нэгэн хөрөгсөл өзэмшдэгтүй ба барьцаа хөрөнгөөс шалтгаалан алдагдлын хасагдуулгыг хүлээн зөвшөөрдөгтүй.

Банкудад урт хугацааны санхүүжилт, зээл олгох нь ерөнхийдөө барьцаатай байдаг; салангид тусдаа зээлүүл барьцаагүй байдаг. Зээлийн алдагдлыг багасгахын тулд банк холбогдох салангид зээл, урьдчилгаа төлбөрийн үнэ цэнийн бууралтын үзүүлэлтүүд илэрсэн даруйд эсрэг талаас нэмэлт барьцаа авна.

Зээл, урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн барьцаанд байгаа барьцааг тухайн хөрөглүүрийн шинж чанараар тодорхойлно. Ерөнхийдөө, санхүүгийн байгууллага тэр дундаа Банкнуудад зээл, урьдчилгаа олгоход барьцаа хөрөнгө шаарддаггүй. Үл хамаарах зүйл бол буцаан худалдан авах гэрээ, үнэт цаасны зээлийн гүйлгээний дагуу авсан барьцаа юм. Өрийн үнэт цаас болон бусад үнэт цаас нь барьцаагүй байдаг.

### 37.2 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зээлийн хүү, гадаад валютын ханш зөрөг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалж санхүүгийн хөрөглүүрийн бодит үнэ цэнэ эсхүл ирээдүйн мөнгөн гүйлгээ өөрчлөгдхөх эрсдэл юм. Банк нь зах зээлийн эрсдэлд өртөх эрсдэлийг арилжааны болон арилжааны бус багц гэж ангилдаг. Арилжааны багцын зах зээлийн эрсдэлийг эрсдэлийн хувьсагчдын хоорондын харилцан хамаарлыг тусгасан Эрсдэлд өртөх үнэ (VaR) аргачлалд үндэслэн удирдаж, хянадаг. Арилжааны бус нөхцөл байдлыг бусад мэдрэмжийн шинжилгээг ашиглан хянаж удирддаг.

#### 37.2.1 Зах зээлийн эрсдэл – Арилжаа (бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар тодорхойлсон санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг багтаасан)

Төлөөлен Удирдах зөвлөл нь хүлээн зөвшөөрч болох эрсдэлийн түвшний хязгаарыг тогтоосон. Банк нь зах зээлийн нөхцөл байдлын янз бүрийн өөрчлөлтийн хэд хэдэн параметр, таамаглалд тулгуурлан эзэмшиж буй зах зээлийн эрсдэлийн байр суурийг үнэлэх, здийн засгийн болзошгүй алдагдлыг тооцлохын тулд Эрсдэлд өртөх үнэ (VaR) аргачлалыг ашигладаг. Эрсдэлд өртөх үнэ (VaR) нь багцын

зах зээлийн үндэд өгөгдсөн итгэлийн түвшин болон тодорхой хугацааны туршид гарч болзошгүй серэг өөрчлөлтийг тооцоолох замаар санхүүгийн эрсдэлийг хэмжихэд ашигладаг арга юм. Банк хүүгийн түвшин, зерүү болон хэлбэлзлийн эрсдэлд бүрэн шугаман бус Эрсдэлд өртөх үнэ (VaR) загварыг ашигладаг. Эдгээр тооцоолол нь вариац/ковариацын матрицаас гаргаж авсан Монте-Карлогийн симуляци дээр үндэслэсэн болно. Валютын ханштай холбоотой Эрсдэлд өртөх үнэ (VaR) -ийн хувьд Банк вариац/ковариацын загварыг ашигладаг. Өмчийн эрсдэлийг нэг хүчин зүйлийн загвар ашиглан тооцдог.

#### Эрсдэлд өртөх үнэ (VaR) аргачлалын зорилго ба хязгаарлалт

Банк нь сүүлийн таван жилийн түүхэн мэдээлэлд үндэслэн арилжааны багцын зах зээлийн үндэд гарч болзошгүй өөрчлөлтийг үнзлэхийн тулд симуляцийн загваруудыг ашигладаг. Эрсдэлд өртөх үнэ (VaR) загварууд нь зах зээлийн хэвийн орчинд зах зээлийн эрсдэлийг хэмжихэд зориулагдсан. Загварууд нь зах зээлийн хэвийн орчинд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлд гарсан аливаа өөрчлөлт нь хэвийн тархалтын дагуу явагдана гэж үздэг. Тархалтыг экспоненциал жигнэсэн түүхэн өгөгдлийг ашиглан тооцоолно. Эрсдэлд өртөх үнэ (VaR)-ийн хэрэглээ нь хязгаарлагдмал байдаг, учир нь энэ нь зах зээлийн үнийн түүхэн хамаараал, хэлбэлзэлд сууриндаг бөгөөд ирээдүйн үнийн хөдөлгөөн статистикийн тархалтыг дагаж болно гэж үздэг. Эрсдэлд өртөх үнэ (VaR) нь мэдээлэл өгөхийн тулд түүхэн өгөгдэлд ихээхэн тулгуурладаг бөгөөд эрсдэлт хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлт, өөрчлөлтийг урьдчилан таамаглах боломжгүй байдаг тул эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлт хэвийн тархалттай нийцэхгүй бол зах зээлийн томоохон өөрчлөлтүүдийн магадлалыг дутуу үнэлж болно. Мен эрсдэлт хүчин зүйлсийн талаарх таамаглал болон тодорхой хэрэглүүрийн здгээр хүчин зүйлсийн хосрондын хамаарлаас шалтгаалан Эрсдэлд өртөх үнэ (VaR)-ийг дутуу эсвэл хэтруулсан тооцож болно. Хэдийгээр өдрийн турш байр суурь өөрчлөгджэй болох ч Эрсдэлд өртөх үнэ (VaR) нь зөвхөн ажлын өдөр бүрийн төгсгөлд багцын эрсдэлийг илэрхийлдэг бөгөөд 99%-ийн итгэлийн түвшингээс хэтэрч болзошгүй алдагдлыг тооцдоггүй.

Практикт арилжааны бодит үр дүн нь Эрсдэлд өртөх үнэ (VaR)-ийн тооцооплосс ялгаатай байх бөгөөд ялангуяа тооцоолол нь зах зээлийн хүнд нехцэлд ашиг, алдагдлын бодит үзүүлэлтийг өгдөггүй. Эрсдэлд өртөх үнэ (VaR) загваруудын найдвартай байдлыг тодорхойлохын тулд бодит үр дүнг тогтмол хянаж, таамаглал болон VaR тооцоололд ашигласан параметрүүдийн үнэн зөвийг шалгадаг. Мен зах зээлийн эрсдэлийн байр суурийг банк зах зээлийн эрс тэс үйл явдлыг тэсвэрлэхийн тулд тогтмол стрессийн тестэд хамруулдаг.

#### Эрсдэлд өртөх үнэ (VaR)-ийн таамаглал

Банкны хамждэг Эрсдэлд өртөх үнэ (VaR) нь зах зээлийн эрсдэлийн одоогийн байр суурийг нэг өдрийн турш өөрчлөгүй тохиолдолд хэтрүүлэхгүй учир болзошгүй алдагдлын 99%-ийн итгэлийн түвшинг ашиглан тооцоолсон тооцою юм. 99%-ийн итгэлийн түвшинг ашиглал нь нэг өдрийн дотор VaR үзүүлэлтээс давсан алдагдал дунджаар зуун хоногт нэгээс илүүгүй байх ёстой гэсэн үг юм.

VaR-ын хязгаар ба алдагдлын хэмжээ нь удирдлагаас тогтоож өгсөн хязгаарт байгаа эсэхийг тогтмол шалгаж үздэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөргөлт дээр нэг өдрийн хугацаанд гарч болох алдагдлын хэмжээг VAR аргаар тооцоолж гаргасныг дор үзүүлэв. Үүнд:

Мянган төгрөгөөр	Түүхэн Симуляци	Монте Карло Симуляци
2022 – 12 сарын 31	(554,115)	(560,089)
2022 – Өдөр бүрийн дундаж	(287,755)	(283,867)
2022 – Хамгийн дээд	(912,898)	(904,982)
2022 – Хамгийн доод	(87,913)	(106,490)
2021 – 12 сарын 31	(224,180)	(230,154)
2021 – Өдөр бүрийн дундаж	(371,540)	(371,453)
2021 – Хамгийн дээд	(601,772)	(605,992)
2021 – Хамгийн доод	(199,845)	(204,929)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрдэлд өртж болох Банкны хэрэngийн дунг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хэрэнгэ, өр төлбөрийн бүртгэлийн дунг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31				
	Төгрөг	Америк доллар	Евро	Бусад	Нийт
<b>Валютаарх санхүүгийн хэрэнгэ ба өр төлбөр</b>					
<b>Хөрөнгө</b>					
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	513,001,397	186,240,178	5,476,270	21,578,432	726,386,277
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршиулсан харилцах, хадгаламж	196,388,296	29,209,892	991,218	4,949,446	231,538,852
Харилцагчдаа олгосон зээл ба урьдчилгаа	1,868,283,818	342,584	-	-	1,868,626,502
Санхүүгийн хэрэнгэ оруулалт – арилжаанах зориулалттай	10,896,733	-	-	-	10,896,733
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хэрэнгэ	128,002,947	-	-	-	128,002,947
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх емчийн хэрэгсэл	768,287,505	189,484,224	-	-	957,771,729
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх емчийн хэрэгсэл	103,350	-	17,116	-	120,466
Хорогдуулсан өртөөр бүртгэх ерийн хэрэгсэл	68,223,496	-	-	-	68,223,496
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	12,785,546	2,248,887	-	-	15,034,433
Бусад санхүүгийн хэрэнгэ	7,886,803	127,194	-	288	8,016,285
<b>Нийт</b>	<b>3,573,861,891</b>	<b>407,653,069</b>	<b>6,484,604</b>	<b>28,628,166</b>	<b>4,014,627,720</b>
<b>Өр төлбөр</b>					
Бусад банкны харилцах, хадгаламж	114,265,555	200,849,324	320,754	96,428	315,533,091
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,550,280,155	170,860,522	5,832,987	22,386,849	2,749,360,513
Бусад зээлээр авсан эх үүсвэр	196,388,492	38,545,645	-	-	234,934,137
Рено	253,049,417	80,180,796	-	-	333,230,213
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	2,286,265	-	-	-	2,286,265
Түрээсийн өвлөгөө	197,130	-	-	-	197,130
Бусад санхүүгийн өр төлбөр	25,499,211	208,416	610	198,793	25,907,030
<b>Нийт</b>	<b>3,141,967,255</b>	<b>490,644,703</b>	<b>6,154,351</b>	<b>22,682,070</b>	<b>3,661,448,379</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>431,894,636</b>	<b>(82,991,644)</b>	<b>330,253</b>	<b>3,946,096</b>	<b>353,179,341</b>

Мянган төгрөгөөр	2021 оны 12 сарын 31				
	Төгрөг	Америк доллар	Евро	Бусад	Нийт
<b>Валютаарх санхүүгийн хэрэнгэ ба өр төлбөр</b>					
<b>Хөрөнгө</b>					
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	209,167,524	8,845,131	5,102,594	27,805,442	250,920,691

<b>Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж</b>	<b>235</b>	<b>16,456,773</b>	<b>4,688,530</b>	<b>7,388,778</b>	<b>28,534,316</b>
<b>Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа</b>	<b>2,231,662,436</b>	<b>5,494,912</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,237,147,348</b>
<b>Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаалах зориулалттай</b>	<b>7,310,813</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7,310,813</b>
<b>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө</b>	<b>80,844,572</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>80,844,572</b>
<b>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл</b>	<b>825,556,052</b>	<b>141,759,715</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>967,315,767</b>
<b>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгсэл</b>	<b>103,350</b>	<b>-</b>	<b>15,035</b>	<b>-</b>	<b>118,385</b>
<b>Хорогдуулсан өртөөр бүртгэх өрийн хэрэгсэл</b>	<b>67,786,597</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>67,786,597</b>
<b>Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</b>	<b>-</b>	<b>759,107</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>759,107</b>
<b>Бусад санхүүгийн хөрөнгө</b>	<b>318,184</b>	<b>280,080</b>	<b>48,323</b>	<b>-</b>	<b>646,587</b>
<b>Нийт</b>	<b>3,422,739,763</b>	<b>173,595,718</b>	<b>9,864,482</b>	<b>35,194,220</b>	<b>3,641,384,183</b>
<b>Өр төлбөр</b>					
<b>Бусад банкны харилцах, хадгаламж</b>	<b>96,249,022</b>	<b>9,479,999</b>	<b>529,189</b>	<b>9,694,579</b>	<b>115,952,799</b>
<b>Харилцагчдын харилцах, хадгаламж</b>	<b>2,703,152,661</b>	<b>123,246,955</b>	<b>8,672,876</b>	<b>21,725,553</b>	<b>2,856,798,045</b>
<b>Бусад зээлзэр авсан эх үүсвэр</b>	<b>184,665,990</b>	<b>67,710,331</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>252,376,321</b>
<b>Репо</b>	<b>87,820,042</b>	<b>66,989,651</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>153,809,693</b>
<b>Үүсмэл санхүүгийн хэрэгсэл</b>	<b>1,549,920</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1,549,920</b>
<b>Түрээсийн еглэг</b>	<b>234,557</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>234,557</b>
<b>Бусад санхүүгийн өр төлбөр</b>	<b>15,447,117</b>	<b>311,052</b>	<b>53,986</b>	<b>35,841</b>	<b>15,847,976</b>
<b>Нийт</b>	<b>3,089,119,309</b>	<b>266,737,988</b>	<b>9,256,041</b>	<b>31,455,973</b>	<b>3,396,569,311</b>
<b>Цэвэр дүн</b>	<b>333,620,454</b>	<b>(93,142,270)</b>	<b>598,441</b>	<b>3,738,247</b>	<b>244,814,872</b>

### 37.2.2 Зах зээлийн эрсдэл -- Арилжааны бус

#### Хүүгийн түвшний эрсдэл

Тодорхой хугацааны заагуудад хүүгийн түвшинг тохируулж өгч байх шаардлагатай позицууд хосрондос таарамжгүй болох үед хүүгийн эрдэлэд бий болдог. Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүгийн эрсдэлийг бий болгодог. Хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүгийн цэвэр орлогод тэр даруй нелөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг (Банкны хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлсийн эдийн засгийн үнэ цэнэд нөлөөлөх учраас). Тодорхой хугацаанд байж болох хүүгийн хувь хэмжээний өөрчлөлтийн хязгаарыг Банкны удирдлага тогтоож өгдөг. Позицуудыг өдөр бүр хянаж байдаг ба хеджинг стратеги хэрэгжүүнэх замаар позицийг хязгаарын хүрээнд удирдаж ажилладаг.

Дараах хүснэгтэд Банкны орлогын тайлангийн зүйлүүдийн, бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүгийн хувь хэмжээний зохицой, боломжит өөрчлөлтуүдэд үзүүлэх мэдрэмжийг харуулав. Орлогын тайлангийн мэдрэмж гэж нэг жилийн хүүгийн цэвэр орлогод хүүгийн өөрчлөлт (2022 оны 12 дугаар сарын 31 ба 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хөвөгч хүүгийн өөрчлөлт)-ийн үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Мянган төгрөгөөр	Өсөлт (Бууралт)	Цэвэр хүүгийн орлогын мэдрэмж	
		2022 он	2021 он
<b>Валютот</b>			
Евро	+/- 120	613	632
Америк доллар	+/- 120	3,394,613	660,229
Төгрөг	+/- 120	5,662,113	3,286,234
Бусад	+/- 120	136,153	31,953

#### Валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ гадаад валютын ханшийн соргөөврчлэлтийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм. Банкны удирдлага гадаад валютын позицууд дээр хязгаар тогтоож өрдөг ба тэдгээрийг тогтмол хянадаг. Үүнээс гадна Банк нь гадаад валютын эрсдэлийг удирдах, хэмжих үйл ажиллагаандaa VaR загварыг хэрэглэдэг. VaR нь тодорхой хугацаанд ба өгөгдсөн итгэлцлийн түвшинд багцын зах зээлийн үнэд гарч болох өөрчлөлтийг ойролцоолон тооцоолох замаар санхүүгийн эрсдэлийг хэмжихэд ашиглагддаг арга юм.

#### 37.3 Хөрвөх чадварын эрсдэл

Төлберийн чадварын эрсдэл гэдэг нь хэвийн болон стресстэй нэхцел байдалд Банк төлберийн үүргээ биелүүлэх боломжгүй болох эрсдэл юм. Энэхүү эрсдэлийг хягаарлахын тулд удирдлага нь үндсан хадгаламжийн баазаас гадна терөлжүүлсэн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг зохион байгуулж, хөрвөх чадварыг харгалзан хөрөнгийг удирдаж, ирээдүйн мөнгөн гүйлгээ болон хөрвөх чадварыг өдөр бүр хянаж байдаг. Үнд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний үнэлгээ, шаардлагатай бол нэмэлт санхүүжилт авахад ашиглаж болох өндөр зэрэглэлийн барьцаа хөрөнгө байгаа эсэх зэргийг багтаасан болно.

Банк нь бэлэн мөнгөний гүйлгээг урьдчилан тооцоолоогүй тасалдсан тохиолдолд амархан татан буугдах боломжтой, зах зээлийн өндөр чадвартай, олон төрлийн хөрөнгийн багцыг хадгалдаг.

Банк нь хангалттай хэмжээний Монгол банкаас шаарддаг түвшнээс илүү хэмжээ бүхий хөрвөх хөрөнгөтэй байдаг. Үүнээс гадна Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийн 6% болон валютын 18%-тай тэнцэх бэлэн мөнгийг дунджаар хоёр долоо хоногийн хугацааны интервалтай Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

Хөрвөх чадварын байдлыг яна бүрийн хувилбараар үнэлж, удирдан чиглүүлдэг бөгөөд өрөнхийдээ зах зээл, ялангуяа Банктай холбоотой стрессийн хүчин зүйлсийг харгалзан үздэг.

**Санхүүгийн өр төлберийг гэрээний үлдэгдэл хугацаагаарх дүн шинжилгээ.**

Доорх хүснэгтэд 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар Банкны санхүүгийн өр төлберийн гэрээний дискаунтлаагүй эргэн төлөлтийн үүрэгт үндэслэсэн төлөгдхөн хугацааг тоймлон харуулав. Эдгээр өр төлберийн хүлээгдэж буй төлберийн хугацааг Тодруулга 36-с харна уу. Мэдэгдэх ёстой аргэн төлөлтийг нэн даруй мэдэгдэх ёстой гэж үздэг. Банк нь олон харилцагчид эрт төлөх хүсэлт гаргахгүй гэж найдаж байгаа ба банкнаас төлбөр төлөхийг шаардаж болох бөгөөд энэ хүснэгт нь банкны хадгаламжийн хадгалалтын түүхэнд заасан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тусгаагүй.

**Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаанаар шинжилсэн шинжилгээ**

<b>Мянган төгрөгөөр</b>	2022 оны 12 сарын 31				
	<b>Хугацаагүй</b>	<b>3 сараас доош</b>	<b>3-6 сар</b>	<b>6 сараас 1</b>	<b>1-6 жил</b>
					<b>5-с дээш жил</b>
<b>Болтан мянга ба Монголбанк дахь харилцах</b>	726,396,277	-	-	-	726,396,277
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	230,580,502	-	-	958,350	231,538,852
<b>Харилцагчад олгосон зээл ба үрьдчилгаа</b>	124,243,656	281,105,720	400,210,939	503,223,130	798,982,474
<b>Санхүүгийн хөрөнгө оруулалт – арилжаанах зориулалттай</b>	-	-	-	-	9,876,322
Бодит үнэ цэнийн зөрчилтэй нь ашиг, алдаатай тайланд бүртгэлдэх санхүүгийн хөрөнгө	-	197,069,026	-	6,806,919	404,959,317
Бодит үнэ цэнийн зөрчилтэй нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэлдэх ерийн хэрэгслэл	-	705,086,000	119,252,967	-	163,118,111
Бодит үнэ цэнийн зөрчилтэй нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэлдэх виктимийн хэрэгслэл	-	-	-	-	120,466
Хорогдуулсан ертөөвөр бүртгэх өртүүн хэрэгслэл	-	59,877,556	-	12,009,977	71,887,533
Үсмэл санхүүгийн хэрэгслэл	8,016,285	-	-	15,034,433	-
Бусад санхүүгийн хөрөнгө	1,089,236,720	1,183,260,746	579,341,463	518,257,563	981,845,832
<b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>	1,089,236,720	1,183,260,746	579,341,463	518,257,563	981,845,832
Бусад банкны харилцах, хадгаламж	41,988,834	221,468,871	21,856,635	33,602,993	413,746
Харилцагчын харилцах, хадгаламж	1,081,916,769	483,199,282	387,112,862	480,751,008	255,929,087
Зээлзэр авсан эх үүсээр	-	8,165,464	38,988,384	83,528,591	32,215,072
Түрээсийн өвлөгөө	-	197,130	-	-	197,130
Рөгөөн хэрэгслэл	244,687,466	8,715,140,32	82,417,048	-	7,335
Бусад санхүүгийн өр төлбөр	5,553,337	20,609,075	-	-	-
Үсмэл санхүүгийн хэрэгслэл	-	-	-	2,286,265	-
Эх үүсээргүй гүйцэтгэлийн баталгаа	3,037,910	-	-	-	3,037,910
<b>Аккредитив</b>	90,277	-	-	-	90,277
Олондоодуулж үзэл	4,300,507	-	-	-	4,300,507
Хөрөнгөийг холбоотой болгошиг өр төлбөр	567,986	-	-	-	567,986
<b>Нийт санхүүгийн өр төлбөр</b>	1,131,507,321	978,327,288	456,674,990	682,635,304	288,565,239
<b>Цэвэр дүн</b>	48,270,601	(204,933,458)	(122,666,472)	164,328,341	(683,280,593)
					180,002,374
					(628,275,207)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдээж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

2024 оны 12 сарын 31						
Мянган төгрөгөөр	Хурацаагүй	3 сараас доош	3-6 сар	6 сараас 1 жил	1-5 жил	5-с дээш жил
Бэлэн мене ба Монголбанк дахь харилцах	250,965,959	-	-	-	-	250,965,959
Харилцагчад огосон зээл бөрьцүүлэв	107,394,547	292,891,420	365,811,853	568,455,204	1,174,310,551	235,969,864
Бусад банж ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	27,749,344	-	-	784,972	-	28,534,316
Санхүүгийн хөрөнөн оруулалт – армийжаатын зорилтуулалттай	-	-	-	-	-	-
Боригт үзэ цэнийн өөрчлөлт нь ашиг, албандааны тайланд	-	-	-	-	-	-
Боригт үзэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэх өөрийн хэргээгээл	-	828,000,000	-	13,944,660	152,407,267	-
Боригт үзэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэх өөрийн хэргээгээл	-	-	-	-	-	-
Хорогдуулсан өртөөөр бүртгэх өөрийн хэргээгээл	-	-	-	471,197	78,603,103	-
Үснэг санхүүгийн хэргээсэл	-	759,107	-	-	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	646,587	-	-	-	-	-
Нийт санхүүгийн хөрөнгө	386,755,437	1,121,680,527	365,811,853	632,871,061	1,406,302,087	480,584,578
Бусад банкны харилцах, хадгаламж	45,700,467	23,646,085	30,485,931	18,078,416	312,657	-
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,073,251,161	652,498,172	332,466,204	588,107,451	198,414,629	372,521,434
Зээлээр авсан эх үүсээр	-	515,617	27,071,730	133,300,863	28,348,161	86,800,666
Түрээсийн өтөлөг	-	-	-	254,748	-	-
Рено хэмжэл	153,809,693	-	-	-	-	153,809,693
Бусад санхүүгийн өр төлбөр	8,331,600	7,037,031	-	-	-	15,368,631
Үснэг санхүүгийн хэргээгээл	-	1,549,920	-	-	-	1,549,920
Эх үсэвэртүйн гүйцэтгэлийн багатгала	3,341,729	-	-	-	-	3,341,729
Аккредитив	693,238	-	-	-	-	593,238
Оглогдоогүй зээл	10,148,186	-	-	-	-	10,148,186
Хөрөнгөтэй холбогтой болгошигүй өр төлбөр	1,775,543	-	-	-	-	1,775,543
Нийт санхүүгийн өр төлбөр	1,296,955,617	585,246,825	390,023,865	739,741,478	227,076,447	459,322,120
Цэвэр дүк	916,199,180	(536,403,702)	24,212,012	156,870,417	(1,179,226,640)	(645,611,191)

### 37.4 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь Банкны үйл явц, боловсон хүчин, технологи, дад бүтэц зэрэг санхүүгийн хэрэглүүрт оролцохтай холбоотой олон янзын шалтгаан, зээл, зах зээл, хөрөвч чадварын эрсдэлээс бусад гадаад хүчин зүйлээс үүдэлтэй шууд болон шууд бус алдагдлын эрсдэл юм.

Банкны зорилго нь санхүүгийн алдагдал болон банкны нэр хүндэд хохирол учруулахаас зайлсхийх, нийт зардлын үр ашигтай байдлыг тэнцвэрхуулэхийн тулд үйл ажиллагааны эрсдэлийг удирдах явдал юм.

Үйл ажиллагааны эрсдэлийг шийдвэрлэх хяналтыг боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн хариуцлагыг <Эрсдэлийн удирдлагын газар, Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, бусад> хариуцдаг. Энэхүү хариуцлагыг дараах чиглэлээр үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын нэгдсэн стандартыг боловсруулснаар дэмждэг:

- ажил гүйлгээний бие даасан зөвшөөрөл зэрэг үүрлийг зохих ёсоор хуваарилах шаардлага;
- ажил гүйлгээг нэгтгэх, хянахад тавигдах шаардлага;
- зохицуулалтын болон бусад хууль эрх зүйн шаардлага, үүнд Монгол Улсын Төв банкны дотоод хяналтын тогтолцоонд тавигдах хамгийн наад захын шаардлагыг дагаж мөрдөх;
- хяналт, журмын баримт бичиг;
- тулгарч буй үйл ажиллагааны эрсдэлийн үучилсэн үнэлгээнд, тавигдах шаардлага, тодорхойлсон эрсдэлийг арилгахад чиглэсэн хяналт, журмын хангалттай байдал;
- үйл ажиллагааны алдагдлыг тайлгахаа шаардлага, арилгах санал болгож буй арга хэмжээ;
- онцгой байдлын төлөвлөгөө боловсруулах;
- сургалт, мэргэжил дээшлүүлэх;
- ёс зүй, бизнесийн стандарт; болон
- эрсдэлийг бууруулах.

Банкны стандартын нийцлийг Дотоод аудитын тогтмол хяналт шалгалтын хөтөлбөрөөр дэмждэг. Дотоод аудитын шалгалтын үр дүнг холбогдох банкны удирдлагатай хэлэлцэж, хураангуйг ТУЗ-д хургуулна.

### 38 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банк нь бизнест учирч болох эрсдэлийг нөхөхийн тулд идэвхтэй удирддаг хөрөнгийн баазыг хадгалдаг. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг бусад хэмжүүрээс гадна Банкны хяналтын хорооноос тогтоосон дүрэм, харьцаа ашиглан хянадаг.

Банкны хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь банкийг гаднаас ногдуулсан хөрөнгийн шаардлагыг хангаж, бизнесээ дэмжих, хувь нийлүүлэгчдийн үзүүлэлтэй хөрөнгийн тулд банкны өндөр зээлжих зэрэглэл, өөрийн хөрөнгийн эрүүл харьцааг хадгалах явдал юм.

Банк нь өөрийн хөрөнгийн бүтцээ удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны эрсдэлийн шинж чанарыг харгалзан түүнд тохируулга хийдэг. Хөрөнгийн бүтцийг хадгалах буюу тохируулахын тулд Банк нь хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашигийн хэмжээг тохируулах, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө буцаан олгох эсхүүл хөрөнгийн үнэт цаас гаргах боломжтой. Өмнөх жилүүдийн зорилт, бодлого, үйл явцад өөрчлөлт ороогүй.

Монгол Улсын Төв банкнаас тогтоосон нийт хөрөнгө болон эрсдэлийн жигнэсэн хөрөнгийн хоорондох хамгийн бага харьцаа нь 12% байна.

Зохицуулалтын капитал нь хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны урамшуулал, тухайн жилийн ашиг зэрэг хурийтлагдсан ашиг, өрөнхий неецээс бүрдэх 1-р түвшний хөрөнгөөс бүрдэнэ. Зохицуулалтын хөрөнгийн хэмжээг Монгол Улсын Төв банкны шаардлага, Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу тооцдог. Зохицуулалтын хөрөнгийн өөр нэг бүрэлдэхүүн хэсэг нь 2-р түвшний капитал бөгөөд үүнд дахин үнэлгээний неөц болон бусад неөц багтана.

Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийг зээлийн, зах зээлийн болон үйл ажиллагааны эрсдэлийн тооцооллыг тусгасан шинж чанаары нь ангилсан эрсдэлийн жингийн шатлалаар хэмждэг.

2022, 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Улсын Төв банкны шаардлагын дагуу тооцсон нийт хөрөнгийн хэмжээ, эрсдэл хүлэсэн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор харуулав.

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
Өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн харьцаа	23.9%	15.3%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	23.9%	15.3%

Мянган төгрөгөөр	2022 он	2021 он
<b>I-р зэрэглэлийн хөрөнгө</b>		
Энгийн хувьцаа	186,774,063	178,000,000
Энгийн хувьцаанд нэмж төлөгдсөн капитал	14,652,725	
Бусад неец	693,669	693,869
Хуримтлагсан ашиг	278,566,612	181,115,726
СТОУС болон МБ-ны журмын зерүү (1)	(18,730,946)	(18,685,389)
Нийт I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	463,956,123	341,144,006
<b>II-р зэрэглэлийн хөрөнгө</b>		
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Хоёрдогч ёглөг	-	-
Нийт II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	-	-
<b>Нийт капитал/капитальын суурь</b>	<b>463,956,123</b>	<b>341,144,006</b>

(1) Тохируулга нь голчлон Монголбанкны журмын дагуу байгуулсан эрсдэлийн сан болон СТОУС-ын дагуу байгуулсан хүлээгдэж буй эрсдэлийн сан хоорондын зерүү болно. Монголбанкны шаардлагын дагуу зерүүг зохистой харьцааны шалгuur үзүүлэлтийн тооцоололд тохируулж өгсөн болно.

12 дугаар сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн хөрөнгийг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

Мянган төгрөгөөр	2022 он		2021 он	
	Хөрөнгө	Жигнэсэн	Хөрөнгө	Жигнэсэн
%				
0	1,716,285,537	-	1,214,180,617	-
20	225,114,450	46,022,890	19,225,416	3,845,083
50	482,167,902	241,083,951	471,495,586	235,747,793
70	-	-	-	-
80	-	-	-	-
90	-	-	-	-
100	1,520,433,731	1,520,433,731	1,882,074,432	1,882,074,432
120	-	-	-	-
150	38,184,877	54,277,316	28,502,097	42,903,146
200	1,613,900	3,227,800	-	-
<b>Тохируулгууд:</b>				
Бүлгийн, тархалтын эрсдэлийн сан	-	-	(2,803,684)	
Үйл ажиллагааны эрсдэлийн харьцаа	35,198,680	-	33,708,759	
Гадаад валютын эрсдэлийн харьцаа	38,179,132	-	37,437,829	
<b>Нийт</b>	<b>3,981,800,396</b>	<b>1,937,423,489</b>	<b>3,615,578,148</b>	<b>2,232,913,358</b>

## 39 Сегмент тайлагнал

Үйл ажиллагааны сегментүүд

Банк нь үндсэн гурван үйл ажиллагааны сегментийн үндсэн дээр зохион байгуулагдсан. Эдгээр үйл ажиллагааны сегментүүдийг хянаж, сегментийн үйл ажиллагааны үр дүнд үндэслэн стратегийн шийдвэрүүдийг гаргадаг.

Хувийн банкны үйлчилгээ, харилцагчийн хувийн харилцах данс, хадгаламж, хадгаламж, хөрөнгө оруулалтын хадгаламжийн бүтээгдэхүүн, хадгаламж, зээлийн болон дебет карт, хэрэглээний зээл, ипотекийн зээлийг төлөөлдөг.

Бизнесийн сегментүүдийн хоорондын ажил гүйлгээ (арилжааны ердийн нөхцөлөөр. Санхүүжилтийг сегментүүдийн хооронд дахин хуваарилдаг бөгөөд үүний үр дүнд санхүүжилтийн зардлын шилжүүлгийг үйл ажиллагааны орлогод тусгагдаг. Эдгээр сангаас авах хүү Банкны хөрөнгийн өртөгт үндэслэн тооцдог.) Бизнесийн сегментүүдийн хооронд орлого, зарлагын бусад, материаллаг зүйл байхгүй. Сегментийн хөрөнгө, ер төлбөр нь үйл ажиллагааны хөрөнгө, ер төлбөрөөс бүрдэх ба балансын дийлэнх хэсгийг бурдуулдэг боловч татвар, зээл гэх мэт зүйлсийг оруулвагүй болно. Дотоод хураамж, шилжүүлгийн үүний тохируулга нь бизнес бүрийн гүйцэтгэлд тусгагдсан. Орлого хуваахаас гэрээг гадны үйлчлүүлэгчдийн орлогыг бизнесийн сегментэд оновчтой хуваарилахад ашигладаг.

Эдгээр бизнесүүдийн талаарх сегментийн мэдээллийг доор үзүүлэв.

Мянган төгрөгөөр	2022 оны 12 сарын 31			
	Иргэд	Бизнес	Хөрөнгө зохицуулалтын газар	Нийт
Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого	280,242,053	17,699,846	106,824,235	404,766,134
Хүү болон түүнтэй адилтгах орлого	163,785	-	-	163,785
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(105,497,584)	(4,648,623)	(72,713,416)	(182,859,623)
Цэвэр хүүгийн орлого	174,908,254	13,051,223	34,110,819	222,070,296
Хураамж ба шимтгэлийн орлого	32,289,174	1,823,342	20,002	34,132,518
Хураамж ба шимтгэлийн зардал	(7,212,890)	(1,159,693)	(455,831)	(8,828,414)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	25,076,284	863,649	(435,828)	25,304,105
Арилжааны цэвэр орлого	6,082,099	350,586	7,028,918	13,461,603
Үйл ажиллагааны бусад (зардал)/орлого	(2,360,648)	652,878	(851,536)	(2,559,306)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн орлого/зардал	13,631,746	(9,999,759)	525,806	4,157,793
Үйл ажиллагааны зардал	(126,468,642)	(10,773,071)	(1,039,158)	(138,280,871)
Сегмент татварын өмнөх ашиг (алдагдал)	90,869,093	(6,064,494)	39,339,021	124,153,620
Орлогын албан татварын зардал	(19,637,520)	1,280,212	(8,501,469)	(26,858,777)
Тайлант жилийн ашиг	71,231,573	(4,774,282)	30,837,552	97,294,843
Нийт хөрөнгө	2,520,388,136	263,670,045	1,380,583,353	4,164,641,534
Нийт ер төлбөр	2,172,611,173	196,070,883	1,289,750,299	3,668,432,355

2021 оны 12 сарын 31

Мянган төгрөгөөр	Иргэд	Бизнес	Хөренгө зохицуулалтын газар	Нийт
Үр ашигт хүүгийн аргачлалаар бодсон хүүгийн орлого	265,401,962	18,734,491	79,363,735	363,500,187
Хүү болон түүнтэй адилтгах орлого	16,804,118	365,384	4,804,139	21,973,641
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(119,723,081)	(6,172,213)	(64,745,227)	(190,640,521)
Цэвэр хүүгийн орлого	182,482,998	12,927,662	19,422,646	194,833,308
Хураамж ба шимтгэлийн орлого	27,543,249	1,496,991	13,367	29,053,607
Хураамж ба шимтгэлийн зардал	(5,375,678)	(876,742)	(466,211)	(6,718,631)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	22,167,571	620,249	(452,844)	22,334,976
Арилжааны цэвэр орлого	1,932,915	83,265	1,990,461	4,006,641
Үйл ажиллагааны бусад (зардал)/орлого	(12,805,534)	(3,789,569)	(946,660)	(17,541,753)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн орлого/зардал	(29,205,161)	(1,612,543)	(1,195,187)	(32,012,890)
Үйл ажиллагааны зардал	(101,273,398)	(8,272,085)	(1,069,940)	(110,605,423)
Сепмент татварын өмнөх ашиг (алдагдал)	43,299,392	(43,018)	17,758,486	61,014,859
Орлогын албан татварын зардал	(10,834,468)	10,764	(4,443,567)	(15,267,271)
Тайлант жилийн ашиг	32,464,924	(32,255)	13,314,919	45,747,588
 Нийт хөренгө	2,497,313,853	171,047,460	1,124,373,142	3,792,734,256
Нийт өр төлбөр	2,242,051,521	111,873,718	1,050,325,078	3,404,250,318

## 40 Тайлагналын үеийн дараах үйл явдал

2022 оны 2 дугаар сарын 24-нд Українда үүссэн мөргөлдөөн эрчимтэй хөгжих, дэлхийн эдийн засагт чухал нелөө үзүүлсэн. АНУ болон Европын орнууд Оросын эсрэг хатуу хориг арга хэмжээ авсан. Барууны түрнүүд одоо байгаа хориг арга хэмжээгээ өргөжүүлэх талаар хэлэлцэж байна. ОХУ нь Монгол Улсын худалдааны гол тунш учраас одоогийн байдлаар авч буй хориг арга хэмжээ болон эдгээр хориг арга хэмжээг нэмэгдүүлэх нь Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд хүчтэй нелөө үзүүлж болзошгүй юм. Гүнзгий хориг арга хэмжээ авсны серэг үр дагавар нь инфляци өндөр өслөлт бөгөөд энэ нь санхүүгийн зах зээлд бага зэрэг саад учруулж болзошгүй юм.

Терийн банкны хувьцааны 20 хүртэлх хувийг 2022-2023 онд үе шаттайгаар олон нийтэд санал болгохоор Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд өнгөрсөн онд 5 хувь, энэ онд 15 хувийн хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгохоор ажиллаж байна.

Удирдлага нь тайлангийн ёдреөс хойш санхүүгийн тайланд нелөө үзүүлэх өөр бусад үйл явдал гарваагүй гэж үзэж байна.

## 41 Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

## 42 Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2022 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болжсон санхүүгийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 10-ны  
өдөр үзүүлж болсан.



Гүйцэтгэх захирал  
Ө.Гантер

Санхүүгийн газрын захирал  
М.Гантуяа